

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сангийн сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/15/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Д.Баярсайхан  
Утас: 51-261663 Цахим хаяг: [bayarsaikhand@audit.gov.mn](mailto:bayarsaikhand@audit.gov.mn)  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 51-261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг  
Утас: 51-261740 Цахим хаяг: [nyamtsetsegj@audit.gov.mn](mailto:nyamtsetsegj@audit.gov.mn)  
Аудитор: Б.Тэгшсүрэн  
Утас: 51-261740 Цахим хаяг: [tegshsurenb@audit.gov.mn](mailto:tegshsurenb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	14
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	17
3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт .....	34
3.5.5 Нэмэлт төсөв .....	35
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	37
4.1 Ерөнхий зүйл .....	37
4.2 Материаллаг байдал .....	37
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	37
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	38
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	45
5.2.1 Төлбөрийн акт .....	46
5.2.2 Албан шаардлага .....	46
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	50

### Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ГГ	Гаалийн газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ГХ	Гаалийн хороо
ДАСХШҮГ	Дотоод аудит, санхүү, хяналт, шинжилгээ үнэлгээний газар
ДАХШҮХ	Дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МАЗ	Монголын авто зам
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
ТГ	Татварын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХ	Татварын хэлтэс
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮААА	Үйлчилгээ, аж ахуйн алба
ҮДТ	Үндэсний давхар даатгал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХС	Эрчим хүчний сайд



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.05.05 № 1260

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-т заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 418.2 тэрбум төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **361.9 тэрбум** төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа ашиглалт хангалтгүй, хэрэгжилт удааширсан 8 төслийн 310.7 тэрбум төгрөг, эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан боловч хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 6 төслийн 62.6 тэрбум төгрөг, 24.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа, 3.4 тэрбум төгрөгийн өглөг, нийт 27.4 тэрбум төгрөгийн тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс Засгийн газрын тогтоолоор нийт 5.6 тэрбум төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 24.7, Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.2.6, 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.2, Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 30 дугаар зүйлийн 30.6, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2, 5 дугаар зүйлийн 5.1.7, 6 дугаар зүйлийн 6.12 гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" 71 дүгээр тогтоолоор Монгол Улсын хилийн боомтыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах "Боомтын хөгжлийн корпорац" ТӨХХК-ийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны эрхлэх асуудлын хүрээнд шинээр байгуулсныг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 75 дугаар тогтоолоор Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн байна. Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 262 дугаар тогтоолоор "Боомтын хөгжлийн корпорац" ТӨХХК-ийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 10 боомтод үйл ажиллагаа явуулах 35365.2 га талбайг ашиглах эрхийг олгосон боловч 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор ашиглах эрхийг цуцалсан, цаашид улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгагдсан үйл ажиллагааг өөрийн орлогоор бие даан бүрэн санхүүжүүлж явуулах чадваргүй байгаагаас гадна хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдалтай, Хилийн боомтын захиргааны зарим чиг үүрэг давхардах, төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 18,370.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 17,367.3 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унаж, уул уурхайн салбарын өсөлт саарснаас эдийн засгийн идэвхжил суларч, импорт буурсан зэргээс Гаалийн байгууллагын орлого 1,065.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон шалтгаалсан байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ." гэж заасны дагуу Ирээдүй өв сан, Хуримтлалын сангийн тайланг нэгтгээгүйгээс жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн эхний үлдэгдлийн дүнг 4,484.9 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Хилийн боомтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай” 62 дугаар тогтоолоор зөвлөлийн 35.5 тэрбум төгрөгийн дүн бүхий санхүүгийн байдлын тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэмж нэгтгэсэн байна.

Мөн Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 61 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 193 дугаар тушаалаар “Монгол үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоог 9 хувь хүртэл бууруулах чиглэлийн дагуу Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Сангийн яамны шинэчлэгдсэн бүтцийг 10 газар, 12 хэлтэс, 170 орон тоотой байхаар, Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Гаалийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 127, Татварын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 100 байхаар тус тус өөрчилж баталсан байна. Гаалийн албаны орон тоог 2244 болгон 222, Татварын албаны орон тоог 1668 болгон 166, Хилийн боомтын захиргааны орон тоог 47 болгон 5, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн орон тоог 31 болгон 6 орон тоогоор тус тус бууруулж, нийт орон тоог 4160 байхаар баталж, гүйцэтгэлээр 4004 албан хаагч ажиллаж шийдвэрийг хангасан байна.

Мөн тайлант онд Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч S&P агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В+ эерэг байсныг ВВ- тогтвортой түвшинд 13 жилийн дараа сайжруулсан, Moody's агентлаг В2 тогтвортойгоос В1 тогтвортой болж 1 шат ахисан, Fitch агентлагаас В+ тогтвортой түвшинд хадгалсан ба Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улсын зээлийн эрсдэлийн үнэлгээг 1 шатаар ахиулж 7/7 түвшингээс 6/7 түвшинд ахиулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,132,272,216.0	13,123,176,020.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,987,138,647.7	4,979,112,050.7
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,344,152,142.0	1,054,996,428.1
33	АВЛАГА	159,338,582.7	204,226,292.8
34	УРЬДЧИЛГАА	534,545,023.9	684,321,102.4
35	БАРАА МАТЕРИАЛ	57,688,809.6	23,077,922.6
36	НӨӨЦИЙН БАРАА	2,839.4	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,049,406,170.7	6,176,442,223.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,658,929,899.6	5,808,486,263.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	3,825,104,947.2	4,554,776,814.6
37100	Урт хугацаат хадгаламж	57,967,999.0	62,618,443.0
37200	Үнэт цаас	431,263,979.9	483,554,350.8
37300	Урт хугацаат зээл	3,335,872,968.3	4,008,604,020.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	833,824,952.4	1,253,709,448.5
39100	Газар	-	1,086,015.8
39200	Биет хөрөнгө	751,237,474.3	1,153,063,707.9
39300	Биет бус хөрөнгө	49,422,588.4	48,776,734.3
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	33,164,889.7	50,782,990.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>16,791,202,115.6</b>	<b>18,931,662,283.4</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,943,008,936.3	7,748,210,876.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,158,875,682.7	4,456,336,598.5
41100	Богино хугацаат үнэт цаас	10,044,464.2	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	3,001,059,900.9	2,856,104,731.0
41300	Өглөг	1,106,178,491.0	1,554,844,927.8
41400	Урьдчилж орсон орлого	41,592,826.6	45,386,939.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,784,133,253.6	3,291,874,277.7
42100	Урт хугацаат үнэт цаас	106,875,646.8	101,675,264.4
42200	Урт хугацаат зээл	2,677,257,606.8	3,190,199,013.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,848,193,179.3	11,183,451,407.1
51	Засгийн газрын хувь оролцоо	9,837,419,116.8	11,172,677,344.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	98,664,653.4	95,546,416.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	185,000,000.0	188,386,613.4
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	59,546,353.9	59,546,353.9
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	14,652,725.0	14,652,725.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	132,941,861.8	134,706,346.9
51200	Хуримтлагдсан үр дүн	9,250,745,994.7	10,583,768,926.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,866,161.1	97,123,568.1
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	(1,053,605.3)
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	1,366.9	-
52	Хяналтын бус хувь оролцоо	10,774,062.5	10,774,062.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>16,791,202,115.6</b>	<b>18,931,662,283.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,602,556,782.9	6,931,964,115.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	442,295,979.9	-
110	Орлогын албан татвар	144,350,403.5	-
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,280,625.2	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	296,664,951.2	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,626,098,559.1	6,084,171,595.7
120	Нийтлэг татварын бус орлого	3,183,714,347.5	2,688,467,740.8
122	Тусламжийн орлого	423,534,015.2	3,315,010,792.3

124	Зээлийн орлого	18,850,196.4	80,693,062.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,534,162,243.9	285,301,751.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,673,019,278.6	4,210,047,325.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,669,750,861.6	4,197,694,452.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,150,016,516.9	1,049,037,555.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,992,737.4	329,388,554.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,273,706.6	40,088,983.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,779,163.8	18,152,488.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,431,650.9	18,208,355.7
2105	Нормативт зардал	2,491,743.4	2,187,668.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,069,832.1	5,834,045.2
2107	Томилолт, зочны зардал	9,494,063.9	7,378,520.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,934,977.8	332,595,465.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	348,548,640.9	295,203,474.4
211	ХҮҮ	1,545,335,661.1	1,778,433,940.4
212	ТАТААС	26,066,423.7	9,693,933.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	948,332,260.0	1,360,529,023.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,268,417.0	12,352,873.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,929,537,504.3	2,721,916,790.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,378,906.5	64,048,511.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	545,745,473.3	1,418,729,296.8
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(531,366,566.8)	(1,354,680,785.4)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,398,170,937.5	1,367,236,004.7

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,257,936,301.8	-	8,257,936,301.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	507,758,600.8	-	507,758,600.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,765,694,902.6	-	8,765,694,902.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	41,414.2	-	41,414.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(3,124,468.4)	-	(3,124,468.4)
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	737,726.0	-	737,726.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	(1,251,426,427.8)	-	(1,251,426,427.8)
8	Зарласан ногдол ашиг	(61,900,904.7)	-	(61,900,904.7)
9	Тайлант үеийн үр дүн	2,398,170,937.5	-	2,398,170,937.5
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,848,193,179.3	-	9,848,193,179.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	125,395,696.8	-	125,395,696.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,973,588,876.2	-	9,973,588,876.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	7,603,475.7	-	7,603,475.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(8,103,107.6)	-	(8,103,107.6)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	(53,810.7)	-	(53,810.7)
17	Өмчид гарсан өөрчлөлт	(89,525,598.1)	-	(89,525,598.1)
18	Зарласан ногдол ашиг	(67,176,079.8)	-	(67,176,079.8)
19	Тайлант үеийн үр дүн	1,367,117,651.3	-	1,367,117,651.3
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,183,451,407.1	-	11,183,451,407.1

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	26,071,541,592.7	13,952,012,259.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	451,577,886.5	-
110	Орлогын албан татвар	144,350,403.5	-
118	Бусад татвар, төлбөр, хураамж	307,227,483.0	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,540,391,043.1	13,151,827,484.8
120	Нийтлэг татварын бус орлого	22,491,971,275.0	10,127,839,460.1
122	Тусламжийн орлого	48,419,768.1	3,023,988,024.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,079,572,663.1	285,301,751.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,464,646,901.1	12,947,604,512.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,464,646,901.1	12,947,604,512.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,477,421,779.7	9,825,271,833.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,942,138.3	330,844,448.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,045,761.7	40,159,395.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,428,210.6	17,630,264.6
2104	Хангамж, бараа материалын зардал	24,959,147.3	125,976,435.8
2105	Нормативт зардал	2,698,512.1	1,281,599.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,132,653.6	6,176,614.4
2107	Томилолт, зочны зардал	7,075,884.1	5,536,566.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,917,176,637.4	9,183,232,409.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,962,834.6	114,434,099.5
211	ХҮҮ	1,538,121,905.7	1,746,914,226.7
212	ТАТААС	26,066,423.7	9,693,933.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,423,036,792.1	1,365,724,518.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(393,105,308.4)	1,004,407,747.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	17,689,409,800.2	20,232,236,572.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	18,105,689,910.5	20,839,470,520.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,105,689,910.5	20,839,470,520.8
2200	Дотоод эх үүсвэрээр	18,105,689,910.5	20,839,470,520.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(416,280,110.3)	(607,233,948.6)
14	Бусад эх үүсвэр	1,019,010,903.4	2,416,690,675.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(37,457,401.5)	391,013,105.7
232	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	148,482,286.6	99,635,096.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	884,735,763.7	1,430,877,965.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	171,732,541.1	594,799,603.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(637,652,877.6)	991,973,403.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,624,791,525.3	3,987,138,647.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,987,138,647.7	4,979,112,050.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
3	ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	429,107,749,600.00	562,490,767,858.90	(133,383,018,258.90)	131.1
31001	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	81,202,648,800.00	119,023,754,098.73	(37,821,105,298.73)	146.6
32001	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	347,905,100,800.00	443,467,013,760.17	(95,561,912,960.17)	127.5
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,020,293,837,000.00	2,685,941,026,137.61	334,352,810,862.39	88.9
12	Татварын бус орлого	3,020,293,837,000.00	2,685,941,026,137.61	334,352,810,862.39	88.9
120	Нийтлэг татварын бус орлого	9,362,649,200.00	27,923,458,025.51	(18,560,808,825.51)	298.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,971,942,000.00	4,799,055,072.20	172,886,927.80	96.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	4,390,707,200.00	23,124,402,953.31	(18,733,695,753.31)	526.7
122	Тусламжийн орлого	3,010,931,187,800.00	2,658,017,568,112.10	352,913,619,687.90	88.3
122002	Хандив тусламж /гадаад/	417,000,000,000.00	335,422,387,835.51	81,577,612,164.49	80.4
122005	Төсвөөс санхүүжих	2,593,931,187,800.00	2,322,595,180,276.59	271,336,007,523.41	89.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,175,588,328,900.00	3,910,698,095,406.41	264,890,233,493.59	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,653,408,457,100.00	2,441,284,495,360.70	212,123,961,739.30	92.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,409,958,400.00	531,465,802,107.45	121,944,156,292.55	81.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,427,275,700.00	180,561,533,164.55	15,865,742,535.45	91.9
210101	Үндсэн цалин	99,330,855,600.00	93,066,900,305.76	6,263,955,294.24	93.7
210102	Нэмэгдэл	51,916,865,500.00	45,895,011,212.74	6,021,854,287.26	88.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,551,043,600.00	20,149,348,347.55	2,401,695,252.45	89.3
210104	Урамшуулал	22,628,511,000.00	21,450,273,298.50	1,178,237,701.50	94.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,367,673,000.00	22,934,192,815.86	2,433,480,184.14	90.4
210201	Тэтгэврийн даатгал	16,516,181,000.00	15,504,742,941.45	1,011,438,058.55	93.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,840,529,300.00	2,296,673,701.91	543,855,598.09	80.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,026,100,000.00	926,809,605.41	99,290,394.59	90.3
210204	Ажилгүйдлийн даатгал	995,425,600.00	827,134,406.54	168,291,193.46	83.1
210205	Эрүүл мэндийн даатгал	3,989,437,100.00	3,378,832,160.55	610,604,939.45	84.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,666,529,100.00	12,420,061,843.66	2,246,467,256.34	84.7
210301	Гэрэл, цахилгаан	4,536,036,600.00	3,557,826,354.75	978,210,245.25	78.4
210302	Түлш, халаалт	5,186,103,400.00	4,955,876,325.10	230,227,074.90	95.6
210303	Цэвэр, бохир ус	903,350,400.00	537,961,510.95	365,388,889.05	59.6
210304	Байрны түрээс	4,041,038,700.00	3,368,397,652.86	672,641,047.14	83.4
2104	Хангамж, бараа материалын зардал	4,030,204,200.00	2,918,869,180.14	1,111,335,019.86	72.4
210401	Бичиг хэрэг	791,989,700.00	598,990,884.64	192,998,815.36	75.6
210402	Тээвэр, шатахуун	1,371,622,100.00	1,111,573,219.55	260,048,880.45	81.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	904,454,200.00	539,817,144.76	364,637,055.24	59.7
210404	Ном, хэвлэл	8,610,000.00	2,580,000.00	6,030,000.00	30.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	141,836,000.00	53,140,826.00	88,695,174.00	37.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	811,692,200.00	612,767,105.19	198,925,094.81	75.5
2105	Нормативт зардал	1,995,846,400.00	1,281,419,711.57	714,426,688.43	64.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	789,391,200.00	325,591,393.57	463,799,806.43	41.2
210502	Хоол, хүнс	204,522,400.00	175,310,888.00	29,211,512.00	85.7

**Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,001,932,800.00	780,517,430.00	221,415,370.00	77.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,846,494,800.00	4,796,549,512.21	2,049,945,287.79	70.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,492,206,500.00	1,262,256,807.00	229,949,693.00	84.6
210602	Тавилга	152,488,500.00	130,954,900.00	21,533,600.00	85.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	508,895,900.00	61,875,106.00	447,020,794.00	12.2
210604	Урсгал засвар	4,692,903,900.00	3,341,462,699.21	1,351,441,200.79	71.2
2107	Томилолт, зочны зардал	4,390,702,700.00	3,260,372,521.48	1,130,330,178.52	74.3
210701	Гадаад албан томилолт	1,382,601,500.00	1,006,057,344.02	376,544,155.98	72.8
210702	Дотоод албан томилолт	2,922,511,000.00	2,188,320,768.46	734,190,231.54	74.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	85,590,200.00	65,994,409.00	19,595,791.00	77.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,665,873,200.00	193,999,091,809.14	51,666,781,390.86	79.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	225,533,833,300.00	179,118,494,576.86	46,415,338,723.14	79.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	503,820,600.00	383,932,160.00	119,888,440.00	76.2
210803	Даатгалын үйлчилгээ	630,475,100.00	524,843,888.72	105,631,211.28	83.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,073,900.00	43,652,537.00	15,421,363.00	73.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	35,089,700.00	3,995,882.90	31,093,817.10	11.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,120,756,700.00	6,163,819,927.77	3,956,936,772.23	60.9
210807	Газрын төлбөр	68,794,200.00	58,059,799.00	10,734,401.00	84.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,162,837,600.00	2,549,757,528.89	613,080,071.11	80.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,551,192,100.00	5,152,535,508.00	398,656,592.00	92.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,019,359,300.00	109,293,711,548.84	44,725,647,751.16	71.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	152,294,787,600.00	108,988,989,215.84	43,305,798,384.16	71.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,724,571,700.00	304,722,333.00	1,419,849,367.00	17.7
211	ХҮҮ	1,292,936,468,200.00	1,208,914,654,372.15	84,021,813,827.85	93.5
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,247,764,115,100.00	1,173,385,014,485.21	74,379,100,614.79	94.0
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,247,764,115,100.00	1,173,385,014,485.21	74,379,100,614.79	94.0
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	45,172,353,100.00	35,529,639,886.94	9,642,713,213.06	78.7
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	45,172,353,100.00	35,529,639,886.94	9,642,713,213.06	78.7
212	ТАТААС	9,800,787,700.00	9,693,933,235.95	106,854,464.05	98.9
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,550,575,500.00	9,550,575,500.00	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,550,575,500.00	9,550,575,500.00	-	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	250,212,200.00	143,357,735.95	106,854,464.05	57.3
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	250,212,200.00	143,357,735.95	106,854,464.05	57.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	697,261,242,800.00	691,210,105,645.15	6,051,137,154.85	99.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	690,649,273,200.00	685,420,462,398.02	5,228,810,801.98	99.2

**Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	689,648,346,300.00	684,943,098,200.00	4,705,248,100.00	99.3
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,000,926,900.00	477,364,198.02	523,562,701.98	47.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,611,969,600.00	5,789,643,247.13	822,326,352.87	87.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	138,062,000.00	133,762,000.00	4,300,000.00	96.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	321,273,800.00	321,000,000.00	273,800.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,043,769,700.00	3,305,634,432.43	738,135,267.57	81.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,862,138,700.00	1,810,293,664.70	51,845,035.30	97.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,725,400.00	218,953,150.00	27,772,250.00	88.7
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,659,472,900,000.00</b>	<b>1,554,901,425,860.17</b>	<b>104,571,474,139.83</b>	<b>93.7</b>
220001	Барилга байгууламж	1,490,286,891,600.00	1,402,264,774,522.71	88,022,117,077.29	94.1
221001	Их засвар	2,968,200,000.00	2,853,862,359.02	114,337,640.98	96.1
222001	Тоног төхөөрөмж	157,711,728,400.00	141,303,356,068.61	16,408,372,331.39	89.6
223001	Бусад хөрөнгө	8,506,080,000.00	8,479,432,909.83	26,647,090.17	99.7
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>(137,293,028,200.00)</b>	<b>(85,487,825,814.46)</b>	<b>(51,805,202,385.54)</b>	<b>62.3</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	(345,968,701,100.00)	(291,378,009,463.77)	(54,590,691,636.23)	84.2
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	208,675,672,900.00	205,890,183,649.31	2,785,489,250.69	98.7
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(1,155,294,491,900.00)</b>	<b>(1,224,757,069,268.80)</b>	<b>69,462,577,368.80</b>	<b>106.0</b>
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,155,294,491,900.00</b>	<b>1,224,757,069,268.80</b>	<b>(69,462,577,368.80)</b>	<b>106.0</b>
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(387,133,881,000.00)	(279,417,657,300.04)	(107,716,223,699.96)	72.2
72	ЗГ-ын зээл	1,542,428,372,900.00	1,504,174,726,568.84	38,253,646,331.16	97.5
722	Гадаад	1,542,428,372,900.00	1,504,174,726,568.84	38,253,646,331.16	97.5
7221	Төслийн зээл	1,542,428,372,900.00	1,504,174,726,568.84	38,253,646,331.16	97.5
322101	Шинээр авах	1,542,428,372,900.00	1,504,174,726,568.84	38,253,646,331.16	97.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,891,428,537,666.32	(1,891,428,537,666.32)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,455,154,842,606.78	(2,455,154,842,606.78)	-
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>8,533</b>	<b>8,094</b>	<b>439</b>	<b>94.9</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>36</b>	<b>36</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	36	36	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>4,182</b>	<b>4,004</b>	<b>178</b>	<b>95.7</b>
620001	Удирдах ажилтан	144	154.00	(10)	106.9
620002	Гүйцэтгэх ажилтан	3,398	3,258	140	95.9
620003	Үйлчлэх ажилтан	618	570	48	92.2
620004	Гэрээт ажилтан	22	22	-	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>4,182</b>	<b>4,004</b>	<b>178</b>	<b>95.7</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,661	1,691	(30)	101.8
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,714	1,525	189	89.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	50	50	-	100.0

650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	-	1	(1)	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	584	570	14	97.6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0
650013	Шатлалгүй цалин	71	89	(18)	125.4
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	100	76	24	76.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		28,411,135,165.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		28,411,135,165.03
122	Тусламжийн орлого		28,411,135,165.03
1221	Хандив тусламж /дотоод/		28,411,135,165.03
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		28,411,135,165.03
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		449,204,257.00
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		23,410,670,852.69
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,005,810,996.30
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,545,449,059.04
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		26,292,233,211.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		26,272,233,411.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		26,179,428,411.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,066,012,086.06
210101	Үндсэн цалин		174,286,298.36
210102	Нэмэгдэл		2,049,625,244.63
210104	Урамшуулал		736,877,034.07
210105	Гэрээт ажлын хөлс		105,223,509.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		367,082,258.15
210201	Тэтгэврийн даатгал		286,957,458.13
210202	Тэтгэмжийн даатгал		20,234,608.51
210203	ҮОМШӨ-ний даатгал		11,292,157.24
210204	Ажилгүйдлийн даатгал		9,554,387.18
210205	Эрүүл мэндийн даатгал		39,043,647.09
2104	Хангамж, бараа материалын зардал		503,545,015.18
210401	Бичиг хэрэг		172,131,410.00
210402	Тээвэр, шатахуун		142,368,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		59,106,235.18
210404	Ном, хэвлэл		30,799,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		99,139,030.00
2105	Нормативт зардал		180,000.00
210502	Хоол, хүнс		180,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		172,532,973.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		12,569,500.00
210602	Тавилга		26,558,000.00
210604	Урсгал засвар		133,405,473.00
2107	Томилолт, зочны зардал		99,495,824.00
210701	Гадаад албан томиллолт		24,175,767.00
210702	Дотоод албан томиллолт		75,320,057.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		648,263,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		566,037,588.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,406,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		80,797,422.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		21,322,316,324.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		21,075,996,894.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		246,319,430.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		92,805,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		92,805,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		87,805,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		19,999,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		19,999,800.00
223001	Бусад хөрөнгө		19,999,800.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		2,118,901,953.83
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(2,118,901,953.83)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(2,118,901,953.83)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино гэж тодорхойлсон байна.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон нэгдсэн төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийн дүн шинжилгээ хийх, орлого төвлөрүүлэх, төсвийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой бодлогын арга хэмжээний хувилбар, төлөвлөгөө, хууль тогтоомжийг боловсронгуй болгох төсөл боловсруулах, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах;
- Эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг татварын бодлогын арга хэрэгслээр дэмжих, зохицуулах, далд эдийн засгийг бууруулах, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэх, татварын ил тод байдлыг сайжруулах, татвараас зайлсхийх, татварын суурийг багасгахын эсрэг бодлогын хувилбар, төлөвлөгөө, татвар, гаалийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох төсөл боловсруулах, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах, татвар, гаалийн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомжийн төсөл, бодлогын хувилбар, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах;
- Олон улсын болон Монгол Улсын санхүү, төсвийн тухайн үеийн болон ирээдүйн нөхцөл байдлыг судлах, таамаглах, дүн шинжилгээ хийх, санхүү, төсвийн төлөвлөлтөд шаардагдах хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх боломжтой бодлогын арга хэмжээг оновчтой болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх;
- Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох, Засгийн газраас санхүүгийн салбарт хэрэгжүүлэх хөтөлбөрийн зураглалыг хөгжүүлэх, Засгийн газрын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төсөл, дунд хугацааны бодлогын хувилбар, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, санхүү, төсвийн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын зохистой, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлогын хувилбар боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах, зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;
- Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангах, төрийн сангийн үйл ажиллагааг зохистой удирдан, төрийн сангийн нэгдсэн дансны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтаар хангах, үйлчилгээ үзүүлэх;
- Хууль тогтоомжийн төсөл, бодлогын хувилбар, хэлэлцээрийн төсөл боловсруулах, гэрээ байгуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хууль зүйн техник, арга зүйн зөвлөмжөөр хангах;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн мэдээллийн найдвартай ажиллагааг бүрдүүлэх;
- Санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, төсвийн эрсдэлийн удирдлагаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, хэрэглэгчийг мэдээллээр хангах.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсөв, татвар, санхүүгийн удирдлагын чадавхыг бэхжүүлж тогтвортой байдлыг хангах, бүтэц, үйл ажиллагааг хөгжүүлэх;
- Төсөв, татвар, санхүүгийн хууль тогтоомжийн шинэчлэл, зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлэх;
- Улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, даатгалын бодлогыг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Санхүүгийн салбарт Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох, Засгийн газрын санхүүгийн хөрөнгө, өрийн төлбөрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, олон улсын санхүүгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн үнэлгээ, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын бодлого, удирдлагаар хангах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөв, санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д *"төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг* гэж заасны дагуу Монгол Улсын ерөнхий сайдын 2026 оны 76 дүгээр захирамжаар томилогдсон Сангийн сайд З.Мэндсайхан нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 57, засгийн газрын тусгай сан 2, төрийн өмчит үйлдвэрийн газар 8, төсөл хөтөлбөр 114, төсвийн төвлөрүүлэн захирагч 2, нийт 183 байгууллагын санхүүгийн тайлан, 18 данс нэгтгэжээ.

### **3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Хууль тогтоомжийн тухай хуулиуд, Монгол Улсын Их Хурлын 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-

2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тэдгээрт хамаарах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг А/3 дугаар тушаал шинэчлэн баталсан;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс аудитын алдаа, зөрчил өмнөх оноос нэмэгдсэн /СЯ, Татварын алба, Сангийн сайд/;
- Төрийн өмчит компанийн гүйцэтгэх удирдлагатай холбоотой 92.9 сая төгрөг /Монголын хөрөнгийн бирж, Үндэсний давхар даатгал/;
- Дотоод хяналтын төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, удирдлагын хяналт болон нягтлан бодох бүртгэл, архивын зохион байгуулалт хангалтгүй /Монголын хөрөнгийн бирж, Татварын алба/;
- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай, гэрээний хугацаа болон төлөвлөсөн ажлын гүйцэтгэл хангалтгүй, ашиглалтад хүлээн авах ажиллагаа бүрэн баталгаажаагүй 310,748.0 сая төгрөг. / Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл 222,544.6 сая төгрөг, Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл 70,890.1 сая төгрөг, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл 12,545.2 сая төгрөг, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл 4,530.2 сая төгрөг, Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл 237.9 сая төгрөг, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл./

Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газар нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал", Сангийн сайдын 2019 оны 291 дугаар тушаалаар баталсан "Сангийн яамны эрсдэлийн удирдлагын бодлого, дүрэм, журам батлах тухай", 2019 оны 274 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд Сангийн сайдын баталсан 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн ДАХШҮХ/01 тоот удирдамжийн дагуу Монгол улсын засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2024 оны хэрэгжилт, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд Төсвийн ерөнхийлөн захирагч бүр төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулсан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг Дотоод аудитын хороонд танилцуулж, холбогдох зөвлөмжийг Дотоод аудитын хорооны 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулж, тайлан тогтоолын хамт хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/02 дугаар тушаалаар баталсан Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 18,931,662.3 сая төгрөг болж өмнөх оноос 2,140,460.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,987,138.6	4,979,112.1	991,973.4
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,344,152.1	1,054,996.4	(289,155.7)
Авлага	159,338.6	204,226.3	44,887.7
Урьдчилгаа	534,545.0	684,321.1	149,776.1
Бараа материал	57,688.8	23,077.9	(34,610.9)
Нөөцийн бараа	2.8	-	(2.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	6,049,406.2	6,176,442.2	128,036.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	3,825,104.9	4,554,776.8	729,671.9
Үндсэн хөрөнгө	833,825.0	1,253,709.4	419,884.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,791,202.1</b>	<b>18,931,662.3</b>	<b>2,140,460.2</b>
Богино хугацаат өр төлбөр	4,158,875.7	4,456,336.6	297,460.9
Урт хугацаат өр төлбөр	2,784,133.3	3,291,874.3	507,741.0
Засгийн газрын хувь оролцоо	9,837,419.1	11,172,677.3	1,335,258.2
Хяналтын бус хувь оролцоо	10,774.1	10,774.1	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>16,791,202.1</b>	<b>18,931,662.3</b>	<b>2,140,460.2</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

### 3.4.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 4,979,112.1 сая төгрөг болж, өмнөх оноос 991,973.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	<b>45,614.9</b>	<b>41,956.4</b>	<b>(3,658.5)</b>
Төгрөг	30,217.2	26,785.2	(3,432.0)
Гадаад валют	15,393.5	15,171.2	(222.2)
Касс арилжааны банк	4.3	-	(4.3)
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>3,941,523.7</b>	<b>4,866,012.0</b>	<b>924,488.3</b>
<b>Төгрөг</b>	<b>2,697,645.4</b>	<b>3,356,964.4</b>	<b>659,319.0</b>
Төрийн сангийн харилцах	2,105,610.6	2,507,762.4	402,151.8
Монгол банк дахь харилцах	353,764.4	759,219.3	405,454.9
Арилжааны банк дахь харилцах	238,270.4	89,982.7	(148,287.6)
<b>Гадаад валют</b>	<b>1,243,878.3</b>	<b>1,509,047.5</b>	<b>265,169.2</b>
Төрийн сангийн харилцах	154,026.1	143,726.5	(10,299.5)
Монгол банк дахь харилцах	224,232.6	56,259.6	(167,972.9)
Арилжааны банк дахь харилцах	865,619.7	1,309,061.4	443,441.7
<b>Хадгаламж</b>	<b>-</b>	<b>71,143.6</b>	<b>71,143.6</b>
<b>Дүн</b>	<b>3,987,138.6</b>	<b>4,979,112.1</b>	<b>991,973.4</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгө дансны 97.7 хувь буюу 4,866,012.0 сая төгрөг банканд байгаа бэлэн мөнгө, 1.4 хувь буюу 71,143.6 сая төгрөг хадгаламж, 0.9 хувь буюу 41,956.4 сая төгрөгийг кассад байгаа бэлэн мөнгө тус тус эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө дансны өсөлтөд Тогтворжуулалтын сан 514,883.0 сая төгрөг, Монголын хөрөнгийн бирж ХК 387,376.2 сая төгрөг, Хадгаламжийн даатгалын корпорац 103,177.6 сая төгрөг, Төрийн банк 93,363.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Тогтворжуулалтын сангийн мөнгөн хөрөнгө 2,286,042.1 сая төгрөг болж өмнөх оноос 514,883.0 сая төгрөгөөр өсөхөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15, 24 дүгээр зүйл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу тусгай сангийн Төрийн сан дахь харилцахад АМНАТ-өөс 395,859.3 сая төгрөг, ААНОАТ-ын орлогоос 119,023.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс шалтгаалсан;
- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн мөнгөн хөрөнгө 1,203,493.8 сая төгрөг болж өмнөх оноос 387,376.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцогч талуудын байршуулсан дэнчин өмнөх оноос нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Хадгаламжийн даатгалын корпорацын мөнгөн хөрөнгө 125,387.7 сая төгрөг болж 103,177.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд арилжааны банкны төлбөр тооцооны харилцах дансны үлдэгдэл 199,467.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн;
- Төрийн банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 915,746.9 сая төгрөг болж өмнөх оноос 93,364.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд хадгаламж Монгол банкин дахь овернайт хадгаламж 170,046.6 сая төгрөг, төгрөгөөрх харилцах дансны үлдэгдэл 302,942.5 сая төгрөгөөр нэмэгдэж, валютын үлдэгдэл 159,457.4 сая төгрөг, арилжааны банкин дахь төгрөгөөрх харилцах дансны үлдэгдэл 154,492.1 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл буурсан нь Сангийн яамны хөрөнгө оруулалтын барьцаа данс 2,760.0 сая төгрөг болж, 139,227.6 сая төгрөгөөр буурсан өмнөх онд Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа дансанд төвлөрүүлсэн 96,886.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож, зарцуулагдаагүй үлдэгдэл 42,579.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс голлон шалтгаалсан бол Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэл 2,000.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй барьцаа дансанд үлдэгдлээр бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсөө, зээлийн хөрөнгө, тээврийн хэрэгсэл болон бусад хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс зориулалт бус, үр ашиггүй зарцуулалт гарсан 1,698.2 сая төгрөг. /Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх төсөл 404.9 сая төгрөг, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл 355.7 сая төгрөг, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 305.8 сая төгрөг, СЯ 276.3 сая төгрөг, Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл 110.2 сая төгрөг, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл 96.3 сая төгрөг, ТЕГ 54.7 сая төгрөг, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл 20.4 сая төгрөг, Нийслэлийн ТГ 20.0 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 16.7 сая төгрөг, ГЕГ-ын Үйлчилгээ, аж ахуйн алба 14.1 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 10.4 сая төгрөг, Өмнөговь аймгийн ТГ 5.0 сая төгрөг, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл 3.6 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ 2.7 сая төгрөг, Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл, Завхан аймаг дахь ГГ/;
- Худалдан авалт, томилолт, зөвлөх үйлчилгээ болон бусад зардлын гүйлгээг и-баримтаар бүрэн баталгаажуулаагүй, зарим баримтыг зөрүүтэй болон тайлант хугацаанаас хойш бүрдүүлсэн 689.6 сая төгрөг. /Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 352.6 сая төгрөг, Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл 255.8 сая төгрөг, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 41.0 сая төгрөг, Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл 33.9 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл 24.3 сая төгрөг, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв 4.9 сая төгрөг, Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 3 дугаар үе шат 0.5 сая төгрөг, Инженер, технологийн дээд боловсрол төсөл 0.8 сая төгрөг/;
- Зардлын ажил гүйлгээг холбогдох дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн 21.4 сая төгрөг. /Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 18.9 сая төгрөг, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл 2.5 сая төгрөг, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл, Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл/;
- Батлагдсан эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан 34.9 сая төгрөг. /Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл 23.7 сая төгрөг, Санхүүгийн мэдээллийн технологийн төв 6.2 сая төгрөг, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 4.2 сая төгрөг, Инженер, технологийн дээд боловсрол төсөл 0.8 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн 454.1 сая төгрөг. /Ухаалаг засаг төсөл-II 274.0 сая төгрөг, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 57.2 сая төгрөг, Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл 32.8 сая төгрөг, Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл 23.5 сая төгрөг, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 21.2 сая төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл 15.8 сая төгрөг, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл 13.1 сая төгрөг, Монголын хөрөнгийн бирж 11.8 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ТГ 3.4 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 1.2 сая төгрөг, Инженер, технологийн дээд боловсрол төсөл, Сэлэнгэ аймаг дахь ГГ/;
- Цалин, НДШ, ХХОАТ-ыг зөрүүтэй тооцож олгосон 82.0 сая төгрөг. /Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл 56.0 сая төгрөг, Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат 34.1 сая төгрөг, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв 13.3 сая төгрөг, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 5.0 сая төгрөг, Баянхонгор аймгийн ТГ 4.9 сая төгрөг, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 2.7 сая төгрөг, Завхан аймгийн ТГ 1.8 сая төгрөг, Говь-Алтай аймгийн ТГ 0.7 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ТГ 0.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн ТГ 0.6 сая төгрөг, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төсөл 0.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ТГ 0.2 сая төгрөг, Дорнод аймаг дахь ГГ, Завхан аймаг дахь ГГ/;
- Батлагдаагүй орон тоонд ажилтан авч ажиллуулан цалин олгосон 154.6 сая төгрөг. /СЯ 145.3 сая төгрөг, Орхон аймаг дахь ГГ 9.3 сая төгрөг, Баян-Өлгийн аймгийн ТГ/;
- Тайлант онд ажил байдлын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа албан хаагч нарт илүү цагийн хөлс олгосон 45.1 сая төгрөг. /ГЕГ-ын YAAA/;
- Урамшуулал, шагнал давхардуулан олгосон 375.0 сая төгрөг. / Ховд аймгийн ТГ 198.7 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 91.0 сая төгрөг, Булган аймгийн ТГ 29.5 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 24.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн ТГ 21.6 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 7.5 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ТГ 1.5 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ТГ 0.3 сая төгрөг/;

- Улсын төсөвт төвлөрүүлэх мөнгийг төвлөрүүлээгүй 63.8 сая төгрөг /Өмнөговь аймгийн ТГ 34.5 сая төгрөг, Орхон аймгийн ТГ 19.1 сая төгрөг ГЕГ-ын СХОХ 10.2 сая төгрөг;/
- Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй 239.1 сая төгрөг. / Сүхбаатар дүүргийн ТХ 172.4 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 55.0 сая төгрөг, Ховд аймгийн ТГ 10.0 сая төгрөг, Дорнод аймгийн ТГ 1.7 сая төгрөг;/
- Нягтлан бодогчийн орон тоотой боловч татварын улсын байцаагч хавсран гүйцэтгэсэн нь дотоод хяналтыг сулруулах эрсдэл үүсгэсэн. /Говьсүмбэр аймгийн ТГ 2.1 сая төгрөг, Баянзүрх дүүргийн ТХ, Сонгинохайрхан дүүргийн ТХ, Чингэлтэй дүүргийн ТХ;/
- Төсөвт төлөвлөөгүй зардал гаргасан 467.6 сая төгрөг. /ТЕГ 466.5 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн ТГ 1.1 сая төгрөг;/
- Үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахуйн нэгээс худалдан авалт хийсэн 34.5 сая төгрөг. /Чингэлтэй дүүргийн ТХ 23.8 сая төгрөг, Ховд аймгийн ТГ 10.7 сая төгрөг;/
- Ажил үйлчилгээ, худалдан авалт, томилолтын төлбөрийг харилцагч байгууллагын дансаар дамжуулалгүй хувь хүний данс, жижиг мөнгөн сангаар дамжуулан олгосон 15.9 сая төгрөг. /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 10.6 сая төгрөг, СЯ 5.4 сая төгрөг;/
- Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй, үлдэгдэлтэй харилцах дансыг хаагаагүй, чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр 3,351.1 сая төгрөг. /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2,375.2 сая төгрөг, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төсөл 975.9 сая төгрөг, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл;/
- Даатгалын гэрээний орлогыг үнэн зөв ангилж бүртгээгүй. /Үндэсний давхар даатгал 70.8 сая төгрөг/.

### 3.4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 1,054,996.4 сая төгрөг болж, өмнөх оноос 289,155.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
<b>Үнэт цаас</b>	<b>1,344,152.1</b>	<b>1,054,996.4</b>	<b>(289,155.7)</b>
Төгрөг	1,344,152.1	1,054,996.4	(289,155.7)
<b>Дүн</b>	<b>1,344,152.1</b>	<b>1,054,996.4</b>	<b>(289,155.7)</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны 95.2 хувь буюу 1,004,215.1 сая төгрөг нь Төрийн банк ХК, 0.8 хувь буюу 50,781.3 сая төгрөг нь “Монголын хөрөнгийн бирж” ХК эзэлж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 289,155.7 сая төгрөгөөр буурахад “Төрийн банк” ХК-ийн Монгол банкны 1 жил хүртэлх хугацаатай үнэт цаасанд байршуулсан хөрөнгө 1,004,215.1 сая төгрөг болж 339,937.0 сая төгрөг, өмнөх онд Нийслэлийн ЗДТГ-аас гаргасан 1 жилийн хугацаатай, жилийн 7.75 хувийн хүүтэй 35,214.2 сая төгрөгийн “Улаанбаатар сити” богино хугацаат үнэт цаасны хугацаа дууссан зэрэг нь хийснээс голлон нөлөөлсөн байна. Тайлант онд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан “Монголын төмөр замын бонд”-д жилийн 17 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай 50,620.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Мөн тайланд Монголын хөрөнгийн биржийн бусад санхүүгийн хөрөнгөд арилжааны банкнуудад байршуулсан 12 сарын хугацаатай хадгаламжийн үлдэгдлийг НББОУС 17-ын дагуу мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөөс 50,781.2 сая төгрөгийн урт хугацаат хадгаламжийг богино хугацаат хөрөнгө оруулалтын дансанд залруулан бүртгэсэн байна.

### 3.4.3 АВЛАГА

Авлага дансны эцсийн үлдэгдэл 204,226.3 сая төгрөг болж, өмнөх оноос 44,887.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
<b>Ажиллагчидтай холбогдсон авлага</b>	<b>24.6</b>	<b>35.4</b>	<b>10.8</b>
<b>Төлбөртэй үйлчилгээний авлага</b>	<b>1,041.3</b>	<b>2,526.5</b>	<b>1,485.2</b>
<b>Татаас, санхүүжилтийн авлага</b>	<b>1,414.0</b>	<b>4,554.3</b>	<b>3,140.3</b>
<b>Дансны авлага /ТӨҮГ/</b>	<b>1,384.3</b>	<b>5,057.8</b>	<b>3,673.4</b>
<b>Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/</b>	<b>37.9</b>	<b>665.0</b>	<b>627.2</b>
<b>Бусад авлага</b>	<b>37,607.8</b>	<b>93,392.8</b>	<b>55,785.0</b>
Байгууллагаас авах авлага	36,461.1	92,201.4	55,740.3
Хувь хүмүүсээс авах авлага	1,146.7	1,191.4	44.7
<b>Зээлийн авлага</b>	<b>117,828.8</b>	<b>97,994.6</b>	<b>(19,834.2)</b>
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	115,489.7	96,377.0	(19,112.7)
Хувь хүмүүст олгосон зээл	111,240.5	92,846.9	(18,393.6)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	0.1	2,045.4	2,045.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	4,249.1	1,484.6	(2,764.4)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	2,339.1	1,617.6	(721.5)
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	2,339.1	1,617.6	(721.5)
<b>Дүн</b>	<b>159,338.6</b>	<b>204,226.3</b>	<b>44,887.7</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт авлагын үлдэгдлийн 55.0 хувийг төрийн өмчит хуулийн этгээд, 34.6 хувийг Засгийн газрын тусгай сан, 8.0 хувийг төсөл хөтөлбөрийн нэгж, 1.7 хувийг төсөвт байгууллага, 0.7 хувийг Бичил санхүүгийн хөгжлийн сангийн дансны авлага тус тус эзэлж байна.

Тайлант онд 96,444.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, 107,782.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төрийн банкны хувь хүмүүст олгосон зээлийн 92,846.9 сая төгрөг, ТӨААН-үүдэд олгосон 2,045.4 сая төгрөг, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд олгосон 1,848.6 сая төгрөгийн авлагаас голлон шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар авч үзвэл хугацаандаа 201,737.1 сая төгрөг, 1-2 жил 817.6 сая төгрөг, 2-3 жил 18.4 сая төгрөг, 4-5 жил 6.4 сая төгрөг, 5-аас дээш жилийн насжилттай 1,646.8 сая төгрөгийн авлагаас Бичил санхүүгийн хөгжил сангийн 1,472.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Тайлант онд ЗГТС-ын авлага 49,931.7 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн авлага 4,025.4 сая төгрөг, төсөвт байгууллагын авлага 1,519.0 сая төгрөг, нийт 55,476.1 сая төгрөгөөр нэмэгдэж, төрийн өмчит компанийн авлага 10,588.4 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл Төсвийн тогтворжуулалтын сангийн өмнөх оны 12 дугаар сарын АМНАТ-ын хуваарилалт 68,388.6 сая төгрөг, Засгийн газрын нөөц сангийн 2,323.9 сая төгрөгийг тус тус авлагаар бүртгэж, тайлант онд барагдуулснаар голлон буурсан. Харин авлагын бууралтад “Төрийн банк” ХК-ийн аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон зээлийн хүүгийн авлага 17,715.5 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- НДШ-ийг илүү тооцож шилжүүлэн авлага үүсгэсэн. /Архангай аймгийн ТХ 1.7 сая төгрөг/;
- Насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй нийт 21.0 сая төгрөг. /Нийслэлийн ТГ 10.3 сая төгрөг, Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр 7.8 сая төгрөг, Баянзүрх дүүргийн ТХ 2.2 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 0.7 сая төгрөг/;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн нийт 449.8 сая төгрөг. /Инженер, технологийн дээд боловсрол төсөл 438.3 сая төгрөг, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл 8.2 сая төгрөг, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 3.4 сая төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийж, актаар баталгаажуулаагүй. /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл/

- Алба хаагчдын 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллын санхүүжилт 12 сарын 31-нд нээгдэж гүйлгээ хийгдсэнтэй холбоотой 0.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн. /Орхон аймаг дахь ГГ/.

### 3.4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 684,321.1 сая төгрөг болж, өмнөх оноос 149,776.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
<b>Урьдчилж гарсан зардал</b>	<b>445,890.3</b>	<b>588,245.5</b>	<b>142,355.2</b>
<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>88,654.7</b>	<b>96,075.6</b>	<b>7,420.9</b>
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6.2	80.4	74.2
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	88,648.5	95,994.5	7,346.0
Цалингийн урьдчилгаа	-	0.6	0.6
<b>Дүн</b>	<b>534,545.0</b>	<b>684,321.1</b>	<b>149,776.1</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 94.0 хувь буюу 643,441.7 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн нэгж, 5.7 хувь буюу 38,706.0 сая төгрөгийг төрийн өмчит хуулийн этгээд, 0.3 хувь буюу 2,173.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын урьдчилгаа тус тус эзэлж байна.

Урьдчилгаа өссөн нь Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн гүйцэтгэгч Пауэр Чайна-Пауэр Чэнгдү түншлэл компанийн олгосон 30.0 хувийн урьдчилгаа төлбөр 79.9 сая ам.доллар буюу Монгол талын хариуцах 5.0 хувийн санхүүжилтээс гарсан 13,671.1 сая төгрөг, БНХАУ-ын Экспорт Импортын банкнаас шилжүүлсэн 272,408.6 сая төгрөгийн төлбөрийг бүртгэсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Урьдчилж гарсан зардлын үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нийт 24,634.8 сая төгрөг /Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл 21,153.8 сая төгрөг, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 3,481.0 сая төгрөг/.

### 3.4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 23,077.9 сая төгрөг болж, өмнөх оноос 34,610.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
<b>Түүхий эд материал</b>	<b>1,355.7</b>	<b>1,505.2</b>	<b>149.5</b>
Тусгай зориулалттай материал	1,244.6	1,397.6	153.0
Эм боох материал	111.1	107.6	(3.5)
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>38,920.6</b>	<b>2,412.1</b>	<b>(36,508.5)</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>3,601.3</b>	<b>2,604.8</b>	<b>(996.5)</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>13,605.7</b>	<b>16,282.6</b>	<b>2,676.9</b>
Бичиг хэргийн материал	5,045.2	7,513.5	2,468.3
Аж ахуйн материал	3,887.4	4,405.4	517.9
Сэлбэг хэрэгсэл	320.4	203.4	(117.0)
Түлш, шатах тослох материал	395.9	248.2	(147.7)
Барилгын засварын материал	41.2	40.6	(0.6)
Хүнсний материал	13.1	1.4	(11.7)
Бусад хангамжийн материал	3,902.5	3,870.2	(32.3)
<b>Мал амьтад</b>	<b>205.5</b>	<b>273.2</b>	<b>67.7</b>
<b>Дүн</b>	<b>57,688.8</b>	<b>23,077.9</b>	<b>(34,610.9)</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материал дансны үлдэгдлийн 55.9 хувь буюу 12,899.8 сая төгрөгийг төсөвт байгууллага, 32.4 хувь буюу 2,701.3 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн нэгж, 11.7 хувь буюу 7,476.8 сая төгрөгийг төрийн өмчит хуулийн этгээд тус тус эзэлж байна.

Тайлант онд бараа материал худалдан авсан 43,168.0 сая төгрөг, шилжүүлэн авсан 3,887.9 сая төгрөг, хандиваар 30.9 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр 2.2 сая төгрөг, бусад 7,808.1 сая төгрөг, нийт 54,897.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 26,418.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, балансаас баланст шилжүүлсэн 61,455.0 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 54.9 сая төгрөг, бусад 1,022.4 сая төгрөг, нийт 88,950.5 сая төгрөгөөр хасагдсан.

Бараа материал дансны үлдэгдэл бууралт нь тайлант онд Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төслийн 37,038.6 сая төгрөгийн шилжүүлэх зорилготой хөрөнгийг аудитын явцад дуусаагүй үйлдвэрлэл дансанд залруулж бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Газрын төлбөрийн зөвлөмжийн тараах материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримт бүрдэлгүй зарцуулсан. /Дархан-Уул аймгийн ТГ 7.0 сая төгрөг/
- Бараа материалын тайланд орлогын баримт, шаардах хуудас дутуу нийт 26.5 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн. / Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл 10.7 сая төгрөг, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 8.0 сая төгрөг, Өвөрхангай аймгийн ТХ 5.2 сая төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл 2.6 сая төгрөг/;
- Татварын газрын гадна хаяг 2024 онд гүйцэтгэх компани руу шилжүүлж бараа материалын бүртгэлд авсан боловч гэрээний дагуу ажлаа бүрэн гүйцэт хийгээгүй. / Ховд аймгийн ТХ 2.4 сая төгрөг/;
- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3 ширхэг хөрөнгийг бүртгэсэн. /Чингэлтэй дүүргийн ТХ 26.9 сая төгрөг/;
- Бараа материал, зардлын ажил гүйлгээг холбогдох дансаар дамжуулалгүй нийт 66.8 сая төгрөгийг шууд зардалд бүртгэсэн. /Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл 23.9 сая төгрөг, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл 35.0 сая төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл 7.9 сая/

**3.4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 6,177,442.2 сая төгрөг болж, өмнөх оноос 128,036.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	789,846.1	844,475.7	54,629.6
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	5,086,381.1	5,166,376.7	79,995.6
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	173,179.0	166,589.8	(6,589.2)
<b>Дүн</b>	<b>6,049,406.2</b>	<b>6,177,442.2</b>	<b>128,036.1</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн 83.0 хувь буюу 5,124,303.5 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн нэгж, 16.4 хувь буюу 1,011,065.6 сая төгрөгийг төрийн өмчит хуулийн этгээд, 0.7 хувь буюу 42,073.1 сая төгрөгийг төсвийн байгууллага тус тус эзэлж байна.

Бусад санхүүгийн хөрөнгө данс 54,629.6 сая төгрөгөөр өссөн нь Хадгаламж даатгалын корпорац 76,205.5 сая төгрөг, Үндэсний давхар даатгал 1,648.2 сая төгрөгийн санхүүгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны төсөвт байгууллагын дүн 6,071.0 сая төгрөгөөр буурсан нь Хөгжлийн хөтөч төсөл 2025 оны бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн 8,027.2 сая төгрөгөөр нэмэгдэж, ашиглагч байгууллагад 6,506.3 сая төгрөг, Хилийн боомтын захиргаа Замын-Үүд дэх гаалийн ажилчдын 3,663.1 сая төгрөгийн өртөгтэй байр ашиглалтад орсонтой холбоотой үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн, Гаалийн ерөнхий газар 9,512.0 сая төгрөгийн хөрөнгийн ашиглагч байгууллагад шилжүүлснээс тус тус шалтгаалсан бол

төслүүдийн хөрөнгө 87,359.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад эргэлтийн хөрөнгийн нийт дүн нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Монголын мянганы сорилтын сангийн УБ хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн 242,242.7 сая төгрөг;
- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн 134,030.4 сая төгрөг;
- УБ-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төслийн 65,058.2 сая төгрөг;
- Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төслүүдийн 62,350.2 сая төгрөг;
- Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 51,493.4 сая төгрөг;
- Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төслийн 47,609.8 сая төгрөг.

Мөн тайлант онд Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 5.4 сая ам.доллар буюу 19,214.9 сая төгрөгийн барилгын ажлын гүйцэтгэлийн төлбөрүүд гарч, Улсын комиссын 2025 оны 16/2025 тоот дүгнэлтээр төслийн хүрээнд байгуулагдсан байгууламжийг байнгын ажиллагаанд залган өмчлөгчийг ашиглагч байгууллага ЦДҮС ТӨХК-д шилжүүлэн өгснөөр бусад эргэлтийн хөрөнгө 289,829.4 сая төгрөгөөр буурсан байна.

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө Хадгаламжийн даатгалын корпорацын 6,589.2 сая төгрөгөөр буурсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Төслийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй нийт 62,607.9 сая төгрөг. /Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл 26,202.4 сая төгрөг, МАЗ-ын авто замын засвар, арчлалтын 42 ширхэг машин нийлүүлэх төсөл 11,202.2 сая төгрөг Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 9,338.8 сая төгрөг, Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлийн төсөл 9,298.7 сая төгрөг, Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл 4,199.4 сая төгрөг, Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл 2,366.4 сая төгрөг/;
- Эрх бүхийн байгууллагын шийдвэргүй хөрөнгө данснаас хассан. /Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 591.3 сая төгрөг/.

**3.4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 4,554,776.8 сая төгрөг болж, өмнөх оноос 729,671.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
<b>Урт хугацаат хадгаламж</b>	<b>57,968.0</b>	<b>62,618.4</b>	<b>4,650.4</b>
Төгрөг	57,968.0	62,618.4	4,650.4
<b>Үнэт цаас</b>	<b>431,264.0</b>	<b>483,554.4</b>	<b>52,290.4</b>
Төгрөг	211,341.5	288,421.8	77,080.3
Гадаад валют	219,922.5	195,132.5	(24,790.0)
<b>Урт хугацаат зээл</b>	<b>3,335,873.0</b>	<b>4,008,604.0</b>	<b>672,731.1</b>
<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>3,281,242.4</b>	<b>3,953,973.4</b>	<b>672,731.1</b>
Хувь хүмүүст олгосон зээл	3,098,321.3	3,542,273.5	443,952.2
Төрийн өмчит ААН-д олгосон зээл	39.1	17,998.4	17,959.3
Хувийн хэвшлийн ААН-д олгосон зээл	182,882.0	393,701.6	210,819.6
<b>Урт хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>54,630.6</b>	<b>54,630.6</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>3,825,104.9</b>	<b>4,554,776.8</b>	<b>729,671.9</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлд 98.8 хувь буюу 4,500,146.2 сая төгрөгийн үлдэгдэлд “Төрийн банк” ХК-ийн 4,437,527.8 сая төгрөг, Үндэсний давхар даатгалын 62,618.4 сая төгрөг, 1.2 хувь буюу 54,630.6 сая төгрөгийн үлдэгдэлд Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын дүн тус тус эзэлж байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт өсөхөд тайлант онд “Төрийн банк” ХК-ийн дотоод эх үүсвэрээс хувь хүмүүст олгосон зээл 443,952.1 сая төгрөг, хувийн хэвшилд олгосон зээл 210,819.6 сая төгрөг, ТӨААН-үүдэд олгосон зээл 17,959.3 сая төгрөг, нийт 672,731.0 сая төгрөг, төгрөгөөрх урт хугацаат үнэт цаас 77,080.3 сая төгрөг, Үндэсний давхар даатгалын урт хугацаат хадгаламж 4,650.4 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

### 3.4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,253,709.4 сая төгрөг болж, өмнөх оноос 419,884.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
<b>Газар</b>	-	<b>1,086.0</b>	<b>1,086.0</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>751,237.5</b>	<b>1,153,063.7</b>	<b>401,826.2</b>
Барилга, байгууламж, орон сууц	349,920.9	423,981.8	74,061.0
Авто-тээврийн хэрэгсэл	18,002.8	22,301.1	4,298.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	138,601.1	159,972.4	21,371.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,339.5	48,144.2	2,804.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6.6	6.6	-
Бусад үндсэн хөрөнгө	7,479.7	5,686.2	(1,793.42)
Дуусаагүй барилга, байгууламж	191,828.9	492,912.3	301,083.4
Ном	57.9	58.9	1.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>49,422.6</b>	<b>48,776.7</b>	<b>(645.9)</b>
Программ хангамж	13,897.7	14,420.49	522.83
Бусад биет бус хөрөнгө	35,524.9	34,356.24	(1,168.69)
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	<b>33,164.9</b>	<b>50,783.0</b>	<b>17,618.1</b>
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	9.0	-	(9.0)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	2,170.5	7,437.3	5,266.9
БЭХ /ТӨҮГ/ + бусад	30,985.4	43,345.7	12,360.3
<b>Дүн</b>	<b>833,825.0</b>	<b>1,253,709.4</b>	<b>419,884.5</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 40.5 хувь буюу 507,684.8 сая төгрөг төсөл хөтөлбөрийн, 39.0 хувь буюу 489,311.0 сая төгрөг төсөвт байгууллагын, 20.2 хувь буюу 253,122.8 сая төгрөг нь төрийн өмчит хуулийн этгээдийн, 0.3 хувь буюу 3,590.8 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын данс тус тус эзэлж байна.

Тайлант онд төсөв болон өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 232,187.2 сая төгрөг, хандиваар авсан 125.4 сая төгрөг, шилжүүлэн авсан 122,316.7 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 11,860.0 сая төгрөг, бусад 291,329.2 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдлээр 3,786.7 сая төгрөг, нийт 661,605.2 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 13,026.0 сая төгрөг, холбогдох тушаал, шийдвэрийн дагуу акталсан 8,836.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 149,965.2 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 4,814.5 сая төгрөг, бусад 3,419.6 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдлоор 11,704.6 сая төгрөг, нийт 191,766.6 сая төгрөгөөр хасагдаж, тайлант оны элэгдлийн зардал 51,040.0 сая төгрөг байна.

Биет хөрөнгөд нөлөө бүхий өөрчлөлт орсон дуусаагүй барилга байгууламж, барилга, байгууламж, орон сууц, машин төхөөрөмжийн данстууд байна. Тухайлбал:

- Барилга, байгууламж орон сууц данс 423,981.8 сая төгрөг болж өмнөх оноос 74,061.0 төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 159,972.4 сая төгрөг болж 21,371.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэхэд Гаалийн албанд Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт төсөл, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслүүдийн хүрээнд бий болсон нийт 72,309.5 сая төгрөгийн хөрөнгийг ГЕГ-ын даргын А/388, А/389, А/606, А608 тушаалаар,

машин тоног төхөөрөмж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”, “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-үүдийн хүрээнд бий болсон нийт 44,142.2 сая төгрөгийн хөрөнгийг ГЕГ-ын даргын А/33, А293, А/294, А/323, А/324, А/325, А/433, А434, А/486 тушаалаар бүртгэсэн нь голлон нөлөөлсөн;

- Дуусаагүй барилга данс 492,912.3 сая төгрөг болж өмнөх оноос 301,083.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь УБ хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл 121,043.9 сая төгрөг, Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн 111,642.9 сая төгрөгийг аудитын явцад залруулж дуусаагүй барилга дансанд бүртгэсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгө 48,776.7 сая төгрөг болж өмнөх оноос 645.9 сая төгрөгөөр буурахад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө 1,335.1 сая төгрөг, Төсөл хөтөлбөрийн хөрөнгө 225.1 сая төгрөг, нийт 1,560.2 сая төгрөгөөр буурч, төсөвт байгууллагын хөрөнгө 914.4 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Бусад хөрөнгө дансны үлдэгдэл 50,783.0 сая төгрөг болж, өмнөх оноос 17,618.1 сая төгрөгөөр өссөн нь Төрийн банкны бусад эргэлтийн хөрөнгө 17,405.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 19.1 сая төгрөг, нийт 17,386.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Газар эзэмших эрхийн гэрчилгээгээр 1,151 м.кв болон 1,168 м.кв талбайтай 2 гэрчилгээтэй газруудыг санхүүгийн тайланд 2,321 м.кв талбайтай 1 газар гэж тусгасан. /Улаанбаатар хот дахь ГГ/;
- Газар эзэмших эрхийн хугацаа дууссан. /Архангай аймгийн ТХ 25.0 сая төгрөг/;
- Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй. /Ханги дахь ГГ/
- Биет тооллого явуулахад бүртгэлгүй хөрөнгө илрүүлсэн. /Ханги дахь ГГ/;
- Үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй хийсэн, акталсан үндсэн хөрөнгийн дүнг тооллогын дүнд оруулж тоолсон. /Сонгинохайрхан дүүргийн ТХ 25.8 сая төгрөг/;
- Хөрөнгийг зөв дансанд ангилж бүртгээгүй, хөрөнгөд тавих дотоод хяналт хангалтгүй./ Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл 1,691.9 сая төгрөг, Өвөрхангай аймгийн ТХ/;
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө, программ хангамжийн ашиглалтын хугацаа, үнэ цэнийг шинэчлэн тогтоох, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх зүйн баримтын дагуу шийдвэрлүүлээгүй 4,140.5 сая төгрөг. /Сангийн яам 2,603.9 сая төгрөг, ГЕГ-ын УААА 1,352.1 сая төгрөг, Монголын хөрөнгийн бирж 119.7 сая төгрөг, Ногоон нуур 1008 айлыг орон сууц төсөл 52.9 сая төгрөг, Хан-Уул дүүргийн ТХ-11.9 сая төгрөг, Дундговь аймгийн ГГ/.

**3.4.9 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**

Богино хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,456,336.6 сая төгрөг болж, өмнөх оноос 297,460.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
<b>Богино хугацаат үнэт цаас</b>	<b>10,044.5</b>	-	<b>(10,044.5)</b>
Төгрөг	10,044.5	-	(10,044.5)
Бусад үнэт цаас	10,044.5	-	(10,044.5)
<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>3,001,059.9</b>	<b>2,856,104.7</b>	<b>(144,955.2)</b>
Төгрөг	2,649,911.3	2,675,899.1	25,987.8
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөв	392,283.4	630,370.5	238,087.1
Хувь хүмүүст олгосон зээл	1,482,900.4	1,520,136.0	37,235.7
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	474,064.1	146,870.0	(327,194.2)
Арилжааны банк	766.3	71,289.4	70,523.0
Санхүүгийн бусад байгууллага	299,897.0	307,233.2	7,336.2

Гадаад валют	<b>351,148.6</b>	<b>180,205.6</b>	<b>(170,943.0)</b>
Бусад гадаад эх үүсвэрээс	351,148.6	180,205.6	(170,943.0)
<b>Өглөг</b>	<b>1,106,178.5</b>	<b>1,554,844.9</b>	<b>448,666.4</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	97.5	32.8	(64.7)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,967.4	888.9	(6,078.5)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,017.9	549.1	(468.8)
Бусад өглөг	1,098,095.7	1,553,374.2	455,278.5
Байгууллагад төлөх өглөг	845,829.8	1,304,201.8	458,372.0
Хувь хүмүүст төлөх өглөг	440.1	1,114.3	674.2
Татварын өглөг /ТӨҮГ/	15,218.5	13,829.6	(1,388.9)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	29.3	83.8	54.6
Дансны өглөг /ТӨҮГ/	236,578.0	234,144.6	(2,433.5)
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>41,592.8</b>	<b>45,386.9</b>	<b>3,794.1</b>
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөв	539.7	539.7	-
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	513.9	304.6	(209.3)
Бусад урьдчилж орсон орлого	40,492.7	44,492.6	3,999.8
Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	46.5	50.1	3.6
<b>Дүн</b>	<b>4,158,875.7</b>	<b>4,456,336.6</b>	<b>297,460.9</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт богино хугацаат өр төлбөрийн 97.1 хувь буюу 4,329,189.0 сая төгрөгийг төрийн өмчит хуулийн этгээдийн, 2.6 хувь буюу 117,328.7 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн нэгжийн, 0.2 хувь буюу 7,495.0 сая төгрөгийг төсөвт байгууллага, 0.1 хувь буюу 2,323.9 сая төгрөгийг ЗГТС тус тус эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн богино хугацаат өр төлбөрийн 67.6 хувь буюу 2,928,214.4 сая төгрөг “Төрийн банк” ХК, 27.6 хувь буюу 1,193,815.4 сая төгрөг Монголын хөрөнгийн бирж, 4.7 хувь буюу 202,280.2 сая төгрөг Үнэт цаасны хадгаламжийн төв, 0.1 хувь буюу 4,878.9 сая төгрөгийн дүнд Үндэсний давхар даатгалын 4,195.6 сая төгрөг, Хадгаламжийн даатгалын корпорацын 654.2 сая төгрөг, Хилийн боомтын корпорацын 22.5 сая төгрөг, Үнэт цаасны клирингийн төвийн 0.9 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөр нэмэгдэхэд Монголын хөрөнгийн биржийн ААНОАТ-ын өглөг 176.9 сая төгрөг, НӨАТ-ын өглөг 118.9 сая төгрөг, тайланд хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцох журмын дагуу 767,789.2 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 726,436.1 сая төгрөгийн дэнчинг битүүмжилснээс голлон шалтгаалсан байна.

Богино хугацаат үнэт цаас 10,044.5 сая төгрөгөөр буурахад Төрийн банк ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд “Ногоон бонд”-ыг 10,044.6 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 12 сарын хугацаатай, жилийн 16.0 хувийн хүүтэйгээр гаргаж, Монгол Улсын ногоон таксономи болон банкны тогтвортой санхүүжилтийн хүрээнд тодорхойлсон шалгуурыг хангасан ногоон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж, 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр эргэн төлснөөс шалтгаалсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшууллыг олгоогүйгээс ХХОАТ-т 4.1 сая төгрөг, даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд 8.1 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан. /Дархан-Уул аймгийн ТГ/;
- Тайлант онд НДШ-ийн дутуу тооцоолсноос өглөгтэй гарсан байна. /Завхан аймгийн ТХ 1.7 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 0.1 сая төгрөг/;
- Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс нийт 19.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн. /Татварын алба 13.9 сая төгрөг, Санхүүгийн мэдээллийн технологийн төв 3.8 сая төгрөг, Багануур дүүргийн ТХ 1.3 сая төгрөг Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 0.1 сая төгрөг/;
- Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нийт 2,971.9 сая төгрөг. /Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 2,858.4 сая төгрөг, Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төсөл 84.5 сая төгрөг, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын

төсөл 15.7 сая төгрөг, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 8.7 сая төгрөг, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 3.9 сая төгрөг, Шивээхүрэн дэх ГГ 0.7 сая төгрөг, Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл/;

- Ажилтны тэтгэмж стандартад заасан шаардлагын дагуу тооцоолж, нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй. /Монголын хөрөнгийн бирж/.

### 3.4.10 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Урт хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 3,291,874.3 сая төгрөг болж, өмнөх оноос 507,741.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 12. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
<b>Урт хугацаат үнэт цаас</b>	<b>106,875.6</b>	<b>101,675.3</b>	<b>(5,200.4)</b>
Төгрөг	106,875.6	101,675.3	(5,200.4)
Бусад үнэт цаас	106,875.6	101,675.3	(5,200.4)
<b>Урт хугацаат зээл</b>	<b>2,677,257.6</b>	<b>3,190,199.0</b>	<b>512,941.4</b>
Төгрөг	2,110,790.6	1,948,762.3	(162,028.3)
ЗГ байгууллага, бусад шатны төсөв	548,821.6	296,270.1	(252,551.5)
Хувь хүмүүсийн зээл	1,154,055.9	1,277,418.1	123,362.2
ТӨААН-үүдийн зээл	7,851.4	38,722.8	30,871.4
Монгол банк	154,033.0	-	(154,033.0)
Санхүүгийн бусад байгууллага	139,818.2	138,016.7	(1,801.5)
Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/	11,587.7	13,052.1	1,464.5
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	928.4	960.3	31.9
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	93,694.3	184,322.2	90,627.9
Гадаад валют	566,467.0	1,241,436.7	674,969.7
Төслийн зээл	188.9	168.4	(20.5)
Гадаадын арилжааны банк	431,517.6	462,271.7	30,754.1
Бусад гадаад эх үүсвэр	108,144.6	-	(108,144.6)
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	10.3	-	(10.3)
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	26,605.6	778,996.6	752,391.0
<b>Дүн</b>	<b>2,784,133.3</b>	<b>3,291,874.3</b>	<b>507,741.0</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 94.5 хувь буюу 3,111,272.1 сая төгрөгийг “Төрийн банк” ХК, 5.1 хувь буюу 166,589.8 сая төгрөгийг Хадгаламжийн даатгалын корпорац, 0.3 хувь буюу 11,866.9 сая төгрөгийг Үндэсний давхар даатгал, 0.1 хувийг Үнэт цаасны хадгаламжийн төвийн 1,185.2 сая төгрөг, Монголын хөрөнгийн биржийн 960.3 сая төгрөг тус тус эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр нэмэгдэхэд “Төрийн банк” ХК-ийн гадаад валютаарх бусад урт хугацаат төлбөр 752,391.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал: Сангийн сайдын 2025 оны 01/8473 дугаартай албан бичиг, Төрийн банкны ТУЗ-ын 2025 оны 58, 68, 73 дугаар тогтоолуудын дагуу Төрийн банк нь олон улсын зах зээлд 2028 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр дуусах хугацаатай 3 жилийн 8.9 хувийн хүүтэй, ногоон төслүүдийн санхүүжилтэд ашиглах зорилгоор 200.0 сая ам.доллар буюу 723,013.9 сая төгрөгийн бондыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Сингапурын хөрөнгийн биржид гаргасан байна.

Урт хугацаат үнэт цаас дансанд Төрийн банк ХК-ийн 2024 оны 31.0 сая ам.долларыг жилийн 13.8 хувийн хүүтэй Нидерландын Эф Си Си Секюритиз Би Ви-ээс 3 жилийн хугацаатай репо хэлцлээр авсан 106,875.6 сая төгрөгийн үнэт цаас бүртгэлтэй байна.

### 3.4.12 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 11,172,677.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,335,258.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 13. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (+)
Засгийн газрын оруулсан капитал	98,664.7	95,546.4	(3,118.2)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	185,000.0	188,386.6	3,386.6
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	59,546.4	59,546.4	-
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	14,652.7	14,652.7	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	132,941.9	134,706.3	1,764.5
Хуримтлагдсан үр дүн	9,250,746.0	10,583,768.9	1,333,022.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	95,866.2	97,123.6	1,257.4
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	(1,053.6)	(1,053.6)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	1.4	-	(1.4)
<b>Дүн</b>	<b>9,837,419.1</b>	<b>11,172,677.3</b>	<b>1,335,258.2</b>

Эх сурвалж: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдлийн 56.7 хувь буюу 6,346,519.6 сая төгрөг төсөл хөтөлбөр, 21.1 хувь буюу 2,354,430.7 сая төгрөг ЗГТС, 16.2 хувь буюу 1,814,247.1 сая төгрөг төрийн өмчит компанийн, ЗГТС, 4.9 хувь буюу 547,940.5 сая төгрөг төсөвт байгууллага, 1.0 хувь буюу 109,539.4 сая төгрөг нь Сангийн яам, Татварын албан хөрөнгө оруулалтын данс болон бусад данс тус тус эзэлж байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 1,335,258.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд хуримтлагдсан үр дүн 1,333,022.9 сая төгрөг болж нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөлт

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,451,754.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос санхүүжих 4,971.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,245.7 сая төгрөг, гадаад эх үүсвэрээс санхүүжих 3,200,000.0 сая төгрөг, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих 550,000.0 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн (284,316.3) сая төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 6,926,655.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 57,206.3 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 1,879,677.4 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 453,113.7 сая төгрөгөөр тус тус бууруулан, нийт 4,536,658.2 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсвөөс хөрөнгийн зардлыг 59,870.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал зардлыг 402,540.8 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийг 18,400.0 сая төгрөгөөр, нийт 361,069.9 сая төгрөгөөр бууруулан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 35 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,175,588.3 сая төгрөг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 2,425,734.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 27,923.4 сая төгрөг, тусламжийн эх үүсвэрээс 335,422.4 сая төгрөг, гадаад эх үүсвэрээс 1,504,174.7 сая төгрөг, дамжуулан зээлдүүлсэн зээлээс (291,378.0) сая төгрөг, бусад 26,063.2 сая төгрөгийг тус тус бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 2,441,284.5 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,554,901.4 сая төгрөг, эргэж төлөгдөх зээл (291,378.0) сая төгрөг, гадаадын төслийн зээлээс санхүүжих зээлд 205,890.2 сая төгрөг, нийт 3,910,698.1 сая төгрөгийг зарцуулж, 117,242.5 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд урсгал шилжүүлгээс бараа, үйлчилгээний зардалд 1,061.4 сая төгрөгийн зохицуулалт хийсэн бөгөөд бараа, үйлчилгээний зардал дотор дараах зохицуулалтыг хийсэн байна. Үүнд: Цалин, хөлс нэмэгдэл урамшууллаас 8,169.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 1,152.8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,068.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 702.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 1,903.6 сая төгрөг, томилот, зочны зардлаас 2,473.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,907.5 сая төгрөг, нийт 17,378.1 сая төгрөгөөр бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 16,800.8 сая төгрөг, нормативт зардалд 1,638.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвт зохицуулалт хийсэн байна.

### Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 18,370,131.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 17,367,358.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,002,773.0 сая төгрөгөөр дутуу буюу 94.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унаж, уул уурхайн салбарын өсөлт саарснаас эдийн засгийн идэвхжил суларч, импорт буурсан зэргээс Гаалийн байгууллагын орлого 1,064,828.1 сая төгрөгөөр тасарснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 14. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	18,370,131.2	17,367,358.2	(1,002,773.0)	94.5
Татварын ерөнхий газар	9,918,444.7	9,918,444.7	-	100.0
үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	429,107.7	562,490.8	133,383.0	131.1
Гаалийн ерөнхий газар	7,777,815.8	6,712,987.7	(1,064,828.1)	86.3
Сангийн яам	247,508.1	390,662.0	143,153.9	157.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	417,000.0	344,193.3	(72,806.7)	82.5
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	9,362.6	1,070.5	(8,292.1)	11.4

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,910,698.1 сая төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр 152,246.6 сая төгрөг, санхүү, төсвийн нэгдсэн удирдлага хөтөлбөр 88,696.1 сая төгрөг, санхүүгийн зах зээлийн зохицуулалт хөтөлбөр (81,015.1) сая төгрөг, Засгийн газрын өрийн үйлчилгээ 70,014.9 сая төгрөг, татвар хураалт, орлого бүрдүүлэлт 29,555.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалжээ.

Хүснэгт 15. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		4,175,588.3	3,910,698.1	264,890.2	93.7
<b>702020</b>	<b>Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага</b>	<b>219,809.1</b>	<b>131,113.0</b>	<b>88,696.1</b>	<b>59.6</b>
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	12,732.2	11,796.0	936.3	92.6
801030	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	205.0	130.4	74.6	63.6
802260	Байр ашиглалтын үйлчилгээ	523.6	523.6	-	100.0
802280	Цахим хуудасны бүртгэлийн хураамж	64.1	64.1	-	100.0
805090	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	880.8	358.2	522.7	40.7
805250	Олон улсын валютын сан дахь МУ-ын хувь оролцоог нэмэгдүүлэх	41,165.2	-	41,165.2	-
807040	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	321.3	321.0	0.3	99.9
807250	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ	7.0	6.6	0.4	94.7
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	501.8	372.5	129.2	74.2
809180	Бусад	6,881.0	6,476.3	404.7	94.1
811010	Засгийн газрын нөөц хөрөнгө	148,225.1	106,116.3	42,108.8	71.6

**Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

815470	Хөрөнгө оруулагчдын харилцааг идэвхжүүлэх	284.4	-	284.4	-
823240	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	18.6	-	18.6	-
829020	Гадаад харилцааг эдийн засагжуулах	2,805.0	918.2	1,886.8	32.7
831050	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	730.0	530.0	200.0	72.6
831100	Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт	826.4	825.5	0.8	99.9
831120	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	3,325.8	2,366.9	958.8	71.2
831140	Блүмбергийн мэдээллийн системийн төлбөр	311.8	307.4	4.5	98.6
<b>702030</b>	<b>Засгийн газрын өрийн үйлчилгээ</b>	<b>996,320.4</b>	<b>926,305.5</b>	<b>70,014.9</b>	<b>93.0</b>
804040	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	250.2	143.4	106.9	57.3
814040	Дамжуулан зээлдүүлсэн зээл	(300,028.2)	(285,301.8)	(14,726.5)	95.1
814090	Засгийн газрын үнэт цаас	677,814.5	660,866.2	16,948.3	97.5
814100	Засгийн газрын зээл	615,122.0	548,048.5	67,073.5	89.1
832010	Ангилалдаагүй бусад зориулалт, арга хэмжээ	3,162.0	2,549.3	612.7	80.6
<b>702040</b>	<b>Санхүүгийн зах зээлийн зохицуулалт</b>	<b>(86,071.8)</b>	<b>(5,056.7)</b>	<b>(81,015.1)</b>	<b>5.9</b>
802160	Улсын зэрэглэл тогтоох үйлчилгээ	878.7	864.4	14.3	98.4
802200	Холбооны суваг ашигласны хөлс	155.2	155.2	0.0	100.0
814040	Дамжуулан зээлдүүлсэн зээл	(6,163.6)	(6,076.3)	(87.3)	98.6
814050	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	(80,942.1)	-	(80,942.1)	-
<b>702050</b>	<b>Татвар хураалт, орлого бүрдүүлэлт</b>	<b>257,896.7</b>	<b>228,341.3</b>	<b>29,555.4</b>	<b>88.5</b>
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	226,374.8	199,570.6	26,804.2	88.2
801030	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	2,913.9	1,840.9	1,073.0	63.2
802050	Мэдээлэл, сурталчилгааны зардал	113.7	112.2	1.5	98.7
802190	Харуул, хамгаалалтын зардал	2,379.3	1,847.6	531.6	77.7
802200	Холбооны суваг ашигласны хөлс	2,581.5	2,339.8	241.7	90.6
802260	Байр ашиглалтын үйлчилгээ	1,374.2	1,347.2	26.9	98.0
805090	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	120.1	119.2	0.9	99.3
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,601.6	4,972.7	628.9	88.8
808110	Нүүлгэн шилжүүлэх зардал	210.0	-	210.0	-
809180	Бусад	16,203.7	16,167.1	36.6	99.8
815690	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	24.0	24.0	-	100.0
<b>702070</b>	<b>Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр</b>	<b>2,078,457.7</b>	<b>1,926,211.3</b>	<b>152,246.4</b>	<b>92.7</b>
801040	Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	1,542,428.4	1,530,638.0	11,790.4	99.2
801050	Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ	417,000.0	344,193.3	72,806.7	82.5
809180	Бусад	99,069.4	39,471.5	59,597.9	39.8
831120	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	19,959.9	11,908.5	8,051.4	59.7
<b>704220</b>	<b>Үндэсний олон нийтийн мэдээлэл</b>	<b>9,550.6</b>	<b>9,550.6</b>	<b>-</b>	<b>100.0</b>
805070	Үндэсний олон нийтийн мэдээллийн үйл ажиллагааг дэмжих	9,550.6	9,550.6	-	100.0
<b>705010</b>	<b>Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг</b>	<b>416,377.6</b>	<b>411,672.3</b>	<b>4,705.2</b>	<b>98.9</b>
805030	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	416,377.6	411,672.3	4,705.2	98.9
<b>705020</b>	<b>Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг</b>	<b>273,270.7</b>	<b>273,270.7</b>	<b>-</b>	<b>100.0</b>
805010	Санхүүгийн дэмжлэг	273,270.7	273,270.7	-	100.0
<b>711060</b>	<b>Хилийн боомтын үйлчилгээ</b>	<b>9,977.4</b>	<b>9,290.0</b>	<b>687.4</b>	<b>93.1</b>
801010	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,164.1	3,859.7	304.3	92.7
808020	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	187.4	123.4	63.9	65.9
809180	Бусад	5,566.1	5,247.0	319.1	94.3
815690	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	59.8	59.8	-	100.0

Засгийн газрын өрийн үйлчилгээ, санхүүгийн зах зээлийн зохицуулалт арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь дотоод, гадаад зээлийн эргэн төлөлт төлөвлөснөөс бага байгаагаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Засгийн газрын өрийн үйлчилгээ хөтөлбөрийн 55,628.0 сая төгрөг - “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Алтай-Улиастайн ЭХС” ТӨХК, “Баруун бүсийн ЭХС” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдүүдийн гэрээний үүргээ хангалтгүй биелүүлснээс дамжуулан зээлийн эргэн төлөлт орж ирээгүй;
- Санхүүгийн зах зээлийн зохицуулалт арга хэмжээний 80,942.1 сая төгрөг - Зоос банк, Анод банкнуудын Засгийн газарт төлж барагдуулах дотоод эх үүсвэрээс олгосон төлбөрийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага хөтөлбөрийн гүйцэтгэл 59.6 хувь буюу 88,696.1 сая төгрөгөөр дутуу биелсэн нь Олон улсын валютын сан дахь Монгол Улсын хувь оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний 41,165.2 сая төгрөгийн гүйцэтгэл гараагүй, Засгийн газрын нөөц хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдэл 42,108.8 сая төгрөг байгаагаас голлон шалтгаалсан байна.

Мөн гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр 92.7 хувь буюу 152,220.0 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээний ашиглалт 11,764.0 сая төгрөг, Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ ашиглалт 72,806.7 сая төгрөгөөр дутуу биелснээс голлон шалтгаалсан байна.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2025 оны төсвийн тодотголоор харьяа байгууллагуудын орон тоо, цалингийн санг бууруулан тодотгосон байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Сангийн яамны шинэчлэгдсэн бүтцийг 10 газар, 12 хэлтэс, 170 орон тоотой байхаар баталсан;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Гаалийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 127, Татварын ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 100 байхаар тус тус өөрчилж баталж, тогтоолыг үндэслэн Гаалийн албаны орон тоог 2244 болгон 222, Татварын албаны орон тоог 1668 болгон 166;
- Хилийн боомтын захиргааны орон тоог 47 болгон 5,
- Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн орон тоог 31 болгон 6 орон тоогоор тус тус бууруулсан.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хоол, унааны зардлыг захирлын тушаал, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээнд тусгасны дагуу ажлын нэг өдөрт олгох дүнг задлан харуулбал:

- Сангийн яамны ТНБД-ын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/240 дүгээр тушаалаар яамны албан хаагчдын хоолны зардлыг ажлын нэг өдөрт 34,000.00 төгрөг, унааны зардлыг 3,000.00 төгрөгөөр тогтоосон;
- “Төрийн банк” ХК Гүйцэтгэх захирлын 2024 оны Х/11 тоот тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 10,000.00 төгрөг, унааны зардлыг 3,000.00 төгрөгөөр тогтоосон;
- Үндэсний давхар даатгал ТУЗ-ийн 2024 оны 24 дүгээр тогтоолоор хоолны зардлыг ажлын нэг өдөрт 15,000.00 төгрөг, унааны зардлыг 1,000.00 төгрөгөөр тогтоосон;
- “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын захирлын 2024 оны А/13 тоот тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 7,000.00 төгрөг, унааны зардлыг 1,000.00 төгрөгөөр тогтоосон;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв Сангийн сайдын 2025 оны 73, Гүйцэтгэх захирлын тушаал 2025 оны А/30 дугаар тушаалаар хоолны зардлыг ажлын нэг өдөрт 15,000.00 төгрөг, унааны зардлыг 5,000.00 төгрөгөөр тогтоосон;
- Төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн ажилтнууд хөлсөөр ажиллах гэрээтэй байдаг тул хоол, унааны хөнгөлөлт олгодоггүй;
- Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллага, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар хоолны мөнгөнд 29,500.00 төгрөг, бусад газар, хороо 25,000.00 төгрөг, Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллага, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар 500.00 төгрөг, бусад газар, хороо унааны мөнгө олгоогүй;

- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий газрын даргын 2024 оны А-12 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.3 дахь заалт дагуу аймаг, дүүргийн Татварын хэлтсийн дарга нар тушаал гарган алба хаагчдын хоолны мөнгөнд 5,000.00-18,000.00 төгрөг, унааны мөнгөнд 0-6,000.00 төгрөг зэрэг харилцан адилгүй байдлаар олгож байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант онд гадаад томилолтод 3,464.3 сая төгрөгийн 94 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,813.9 сая төгрөгийн 81 арга хэмжээний гүйцэтгэл гарсан байна. Зорилтот түвшин батлуулдаг төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад байгууллагын гадаад томилолтын зарцуулалтыг эдийн засгийн ангиллаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд: гадаад томилолтоос 441.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас 802.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 822.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 232,269.5 сая төгрөгийн программ хангамж, лицензүүд ашиглаж байгаагаас 175,955.7 сая төгрөгийн программ хангамж, лицензүүд нь санхүүгийн тайланд бүртгэлтэй, 56,313.8 сая төгрөгийн программ хангамж, лицензүүд бүртгэлгүй байна.

Хурал зөвлөгөөн зохион байгуулахад харьяа байгууллагууд нийт 1,853.5 сая төгрөгийн 432 арга хэмжээ төлөвлөснөөс эрх бүхий этгээдийн баталсан шийдвэртэйгээр 1,768.2 сая төгрөгийн 327 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд мэдээлэл түгээх, мессеж илгээх, постер байршуулах, мэдээ, нэвтрүүлгийн ярилцлагад нийт 692.7 сая төгрөгийн хэвлэл мэдээллийн зардал гаргасан байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын хувьд Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нь харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчийн 100 хувийн эзэмшилтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 5 төрийн өмчит хуулийн этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлтэй, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХК-д нэгтгэгдсэн, “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ, “Хилийн боомтын корпорац” ТӨХХК нь улсын төсвөөс санхүүжиж байна. Төрийн өмчит хуулийн этгээдийн ашиг тайлант онд дараах байдалтай байна. Үүнд:

- Хадгаламжийн даатгалын корпорац- 183,912.8 сая төгрөг;
- “Төрийн банк” ХК - 96,361.0 сая төгрөг;
- “Монголын хөрөнгийн бирж” ХК – 31,821.7 сая төгрөг;
- “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХК – 4,822.2 сая төгрөг;
- “Үндэсний давхар даатгал” ХК – 3,363.7 сая төгрөг;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сангийн сайдын багцын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээгээр 6,384.0 сая төгрөг, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 1,806.5 сая төгрөг, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 89,987.8 сая төгрөг, харьцуулалтын аргаар 7,252.2 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 2,742.3 сая төгрөг, нийт 108,172.8 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Үүнд,

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18,470.0 сая төгрөг;
- Урсгал төсвөөс 21,372.7 сая төгрөг;
- Өөрийн хөрөнгөөр 68,330.1 сая төгрөг

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 67,827.8 сая төгрөгийн 139, ерөнхий гэрээ байгуулах аргаар 6,156.5 сая төгрөгийн 7, нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар 1,145.4 сая төгрөгийн 12, харьцуулалтын аргаар 5,405.8 сая төгрөгийн 97 худалдан авалт,

шууд худалдан авалтын аргаар 688.8 сая төгрөгийн 41 бараа, ажил, нийт 81,224.3 сая төгрөгийн бараа, үйлчилгээ, хөрөнгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй, 204.1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. /Баянгол дүүргийн ТХ 31.5 сая төгрөг, Нийслэлийн ТГ 31.5 сая төгрөг, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 25.0 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 22.7 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн ТХ 29.8 сая төгрөг, ТЕГ 88.6 сая төгрөг/;
- Худалдан авалтын 86.4 сая төгрөгийн мэдээллийг цахим мэдээллийн системд мэдээлээгүй. /Баянгол дүүргийн ТХ 49.5 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 36.9 сая төгрөг/;
- Төслийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй байгаа нь төслийн үйл ажиллагаа удааширах, төсөл хугацаандаа хэрэгжихгүй болох эрсдэлтэй. /Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл, Ухаалаг засаг төсөл-II/;
- Төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй төсөл арга хэмжээ, худалдан авалт, гэрээт үйлчилгээг 3,047.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн /Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл 2,817.5 сая төгрөг, СЯ 230.0 сая төгрөг /.

**3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан Сангийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 5 хөтөлбөрийн 14 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан бөгөөд Сангийн яамны ДАСХШҮГ-аас хэрэгжилтийг 82.6 хувиар үнэлсэн байна.

Хүснэгт 15. Сангийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилт

САНГИЙН САЙД							
А. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН			ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ				
Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Дугаар	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		Шалгуур үзүүлэлтийн хүрээ		
			Шалгуур үзүүлэлт		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
				Нэгж			
<b>70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт</b>							
24	24.1.1 Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулна.	24.1.1.1	Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	хувь	100.0	86.3	
		24.1.1.2	Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100.0	100.0	
		24.1.1.3	Бараанд хийх гаалийн шалгалтаас чөлөөлөх	хувь	65.0	66.0	
		24.1.1.4	Гаалийн хяналт шалгалтад рентген, тоног төхөөрөмжийн ашиглалт	хувь	50.0	66.0	
	24.1.2	Татвар хураалтыг сайжруулж, татварын өрийг бууруулна.	24.1.2.1	Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт	хувь	60.0	63.6
			24.1.2.2	Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт	хувь	50.0	33.9
			24.1.2.3	Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол, өр барагдуулалт	хувь	80.0	81.9
			24.1.2.4	Татварын цахим тайлан авалт	хувь	80.0	82.8
			24.1.2.5	Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт	хувь	1.0	0.4
	<b>71106 Хилийн боомтын үйлчилгээ</b>						
24	24.2.1	Голлох боомтуудын төмөр замын нарийн царигийн холболтын ажлыг дуусгаж, экспортын хүчин чадлын хэмжээг нэмэгдүүлнэ.	24.2.1.1	Авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийн явц	хувь	40.0	1
	24.2.2	Боомтуудын усан хангамж, цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	24.2.2.1	Боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалт	тоо	3.0	3

24.2.3	Олон улсын болон 2 талын зэрэглэлтэй боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	24.2.3.1	Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтын явц	тоо	25.0	12
		24.2.3.2	Тоног төхөөрөмжөөр хангагдсан гаалийн шалган нэвтрүүлэх цэг	тоо	16.0	4
		24.2.3.3	Цагаандэл-Уул хилийн боомтын байгууламжийн бүтээн байгуулалтын явц	хувь	50.0	15

Боомтуудын усан хангамж, цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалтад 245,659.2 сая төгрөг төлөвлөснөөс 239,304.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр ажлууд бүрэн ашиглалтад орсон. Мөн тайлант хугацаанд хэрэгжээгүй дараах хөтөлбөр арга хэмжээ байна. Үүнд:

- Голлох боомтуудын төмөр замын нарийн царигийн холболтын ажлыг дуусгаж, экспортын хүчин чадлын хэмжээг нэмэгдүүлэх хөтөлбөрийн авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдэд 2,978.3 сая төгрөг төлөвлөснөөс 2,772.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан боловч хэрэгжилт хангалтгүй;
- Олон улсын болон 2 талын зэрэглэлтэй боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтын арга хэмжээнд 1,861.4 сая төгрөг төлөвлөж, 1,732.8 сая төгрөгийг зарцуулсан боловч гүйцэтгэл 48.0 хувийн гүйцэтгэлтэй, хугацаа болоогүй, Тоног төхөөрөмжөөр хангагдсан гаалийн шалган нэвтрүүлэх 16 цэг байгуулахаар 1,191.3 сая төгрөг төлөвлөж 1,109.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан боловч 25.0 хувийн хэрэгжилттэй, 4 цэг байгуулсан, Цагаандэл-Уул хилийн боомтын байгууламжийн бүтээн байгуулалтын явцыг 50.0 хувьд хүргэхээр 3,722.9 сая төгрөгийн төсөвтэй төлөвлөсөн боловч 30.0 хувийн хэрэгжилттэй 3,465.7 сая төгрөг зарцуулсан байна.

Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах хөтөлбөрийн улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний биелэлт тасарсан шалтгааныг Хүснэгт 14-т тусгасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төлөвлөхдөө зорилтот түвшинг үнэн зөв бодитой төлөвлөдөггүй өмнөх оны зорилтот түвшинг өөрчлөөгүй, хэрэгжих боломжтой арга хэмжээг тусгадаггүй зэргээс төсвийн зардлын гүйцэтгэл, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийн биелэлт уялдахгүй, үр дүнг үнэлэх боломжгүй байна.

### 3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,545.4 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 23,410.7 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 449.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3,005.8 сая төгрөг, нийт 28,411.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр төслөөс Сангийн яаманд 374.1 сая төгрөг, ДЭМБ-ын дэмжлэгээр санхүүжүүлэх “Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ хийх” ажилд Гаалийн ерөнхий газарт 64.3 сая төгрөг, Хилийн боомтын захиргаанд 10.7 сая төгрөг, нийт 449.2 сая төгрөг;
- Засгийн газрын 103 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас Сангийн яаманд 20,302.9 сая төгрөгийг арбитрын шүүхийн төлбөрт, Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засаг дарга нараас Татварын газар, хэлтсийн үйл

ажиллагааг дэмжих, зарим үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зэргээр Татварын албанд 2,369.5 сая төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд аймгуудын ЗДТГ-аас Гаалийн албанд 738.3 сая төгрөг, нийт 23,410.7 сая төгрөг;

- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс Татварын албанд 3,005.8 сая төгрөг;
- Төсөвт байгууллагын өмнөх оны туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давснаар Татварын албанд 671.1 сая төгрөг Гаалийн албанд 755.7 сая төгрөг, Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-д 50.0 сая төгрөг, Хилийн боомтын захиргаанд 34.9 сая төгрөг, Сангийн яаманд 33.7 сая төгрөг, нийт 1,545.4 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 3,066.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 367.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 503.5 сая төгрөг, нормативт зардалд 0.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 172.5 сая төгрөг, томилолт, зочны зардалд 99.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 648.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 21,322.3 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 5.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 87.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 20.0 сая төгрөг, нийт 26,292.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 251.0 сая төгрөгийг төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 1,867.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/3312 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,346,770.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 43,467.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 5,628,776.6 сая төгрөг болж, өмнөх оноос 29.5 хувиар өссөн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзсэн.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,628,776.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 56,287.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлт бүтээмжийн зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаас Сангийн яаманд даалгасан чиглэлийн дагуу төрийн хэмнэлттэй холбоотой авах арга хэмжээний тухай зөвлөлийн шийдвэрийн төслийн хамт тус тус боловсруулан 2025 оны 01/3723 тоот албан бичгээр хүргүүлсэн;
- Засгийн газрын 2019-2024 онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх, холбогдох тооцоог нийлэх талаар 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 242,900.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн;
- Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын хүрээнд захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэл санхүүжилт байршуулсныг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр гэрээ байгуулаагүй 7 төслийн 132,600.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн болон өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 2,465.8 сая төгрөг. / ТЕГ 521.2 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ТХ 427.1 сая төгрөг, СЯ 421.7 сая төгрөг, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 305.8 сая төгрөг, Ухаалаг засаг төсөл-II 292.3 сая төгрөг, Монголын хөрөнгийн бирж 188.1 сая төгрөг, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа 160.0 сая төгрөг, Орхон аймаг дахь ТГ 107.6 сая төгрөг, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл 96.3 сая төгрөг, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл 56.0 сая төгрөг, ГЕГ-ын ҮАА 14.1 сая төгрөг, ГЕГ-ын СХОХ 12.2 сая төгрөг, Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр-I шат 7.8 сая төгрөг, Өмнөговь аймаг дахь ТГ 4.9 сая төгрөг, Дархан-Уул аймаг дахь ГГ 3.6 сая төгрөг, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 3.2 сая төгрөг, Завхан дахь ГХ 2.3 сая төгрөг, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл 1.6 сая төгрөг/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй нийт 82,561.0 сая төгрөгийн 39 зөрчил илэрснээс 33,299.4 сая төгрөгийн 13 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 46,288.2 сая төгрөгийн 24 зөрчилд зөвлөмж өгч, 2,973.4 сая төгрөгийн 2 асуудалд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний дүн, бусад мэдээг хоцроож мэдээлсэн нийт 36,743.3 сая төгрөг. /Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл 23,241.6 сая төгрөг, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл 4,348.1 сая төгрөг, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл 3,403.6 сая төгрөг, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа 2,358.8 сая төгрөг, Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл 1,450.0 сая төгрөг, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 614.6 сая төгрөг, Газрын тос боловсруулах үйлдвэр төсөл, Татварын алба 398.0 сая төгрөг, "Ногоон нуур 1008 айлыг орон сууц" ТХН 389.5 сая төгрөг, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв 231.5 сая төгрөг, Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл 165.2 сая төгрөг, Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл 81.3 сая төгрөг, Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл 61.1 сая төгрөг, СЯ, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл;
- Шилэн дансны цахим системд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээний дүн, бусад мэдээг мэдээлээгүй нийт 45,817.7 сая төгрөг. /Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 16,432.5 сая төгрөг, Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл 15,136.1 сая төгрөг, Инженер, технологийн дээд боловсрол төсөл 8,024.2 сая төгрөг, Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл 3,815.1 сая төгрөг, Татварын алба 1,384.1 сая төгрөг, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 448.4 сая төгрөг, Гаалийн алба 426.5 сая төгрөг, Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл 143.3 сая төгрөг, Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 7.5 сая төгрөг, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл/.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан нийцлийн аудитаар нийт 19,287.2 сая төгрөгийн 47 зөрчил илэрснээс 4,860.9 сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 14,426.3 сая төгрөгийн зөрчилд 34 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

##### Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн төсвөөс үндсэн чиг үүрэгээ хэрэгжүүлэх санхүүжилтэд 1,302.6 сая төгрөгийг давхардуулан авч зарцуулсан. /Сүхбаатар дүүргийн ТХ 357.2 сая төгрөг, Баянзүрх дүүргийн ТХ 238.9 сая төгрөг, Налайх дүүргийн ТХ 150.0 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн ТХ 132.4 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн ТХ 123.1 сая төгрөг, Нийслэлийн ТГ 96.4 сая төгрөг, Баянгол дүүргийн ТХ 96.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ТГ 76.1 сая төгрөг, Хан-Уул дүүргийн ТХ 22.4 сая төгрөг, Багануур дүүргийн ТХ 6.8 сая төгрөг, Багахангай дүүргийн ТХ 3.4 сая төгрөг /;
- Татварын улсын байцаагч нарт сар, улирлын урамшууллыг ажлын үр дүнг бодитой тооцоогүй, хавтгайруулан олгосон. /Хөвсгөл аймгийн ТГ 351.1 сая төгрөг/;
- Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа Интерактив би ай би ХХК-ны Эмиралд программ нь НББ-д ашиглах программ хангамжийн жагсаалтад байхгүй. /Татварын алба, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл/;
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалын маягтаар тайлагнаагүй, санхүүгийн тайлан бэлтгэх үндэслэл, тайлбар тодруулга бэлтгээгүй. /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл/;
- Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн 264.3 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 96.6 сая төгрөгөөр тусгагдаж 167.7 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн. /Улс хоорондын шуудан илгээмжийн ГГ/;
- Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд ирүүлээгүй. /Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь төсөл, Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл, Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл, Үндэсний давхар даатгал /;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн дагуу иж бүрэн толилуулаагүй. / Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 3 дугаар үе шат, Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл/;
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт нь шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжтой нийцээгүй. /Шивээхүрэн дэх ГГ, Гашуунсухайт дахь ГГ/;
- Гаалийн улсын байцаагч нарын хэрэглэх дүрэмт хувцас, ялгах тэмдэг нь эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр, батлагдсан стандарт, нормгүй байгаагаас дүрэмт хувцасны үнийн тариф, зардлыг үндэслэлтэйгээр тооцоолох боломжгүй нөхцөлийг бүрдүүлсэн. / ГЕГ СХОГ/;
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй тээврийн хэрэгсэл бүртгэлтэй. /ГЕГ-УААА, СЯ, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл/;
- Төслийн удирдлага, голлох мэргэжилтнүүдийн тогтвортой байдал болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй. /Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл/;
- Бусад яам, газрын албан тушаалтнуудад гадаад томилолт олгож, батлагдсан төсөө хэтрүүлээгүй боловч зориулалт бусаар зарцуулсан нийт 292.3 сая төгрөг. /Ухаалаг засаг төсөл-II/;
- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай, гэрээний хугацаа болон төлөвлөсөн ажлын гүйцэтгэл хангалтгүй, ашиглалтад хүлээн авах ажиллагаа бүрэн баталгаажаагүй нийт 17,075.3 сая төгрөг. / Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл, Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл/;
- Барилга байгууламжийг өмчийн бүртгэлд бүрэн тусгаж, хариуцагч байгууллагаар баталгаажуулаагүй. /Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл/.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

## Төсвийн ерөнхийлөн захирагч:

### 4.4.2.1 Зөвлөмж

Илрүүлэлт 1: “Боомтын хөгжлийн корпорац” ТӨХХК нь цаашид улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгагдсан үйл ажиллагааг өөрийн орлогоор бие даан бүрэн санхүүжүүлж явуулах чадваргүй байгаагаас гадна хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдалтай, төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" 71 дүгээр тогтоолоор байгуулагдсан хэлэлцээр уулзалтын түвшин дэх ажлууд эхэлсэн, төсөв 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ТУЗ-ын хурлаар батлагдаж ерөнхий захирлын цалинг 9.3 сая төгрөг, менежерүүдийн цалинг 5.0 сая төгрөг, нягтлан бодогчийн цалинг 3.0 сая төгрөгөөр тогтоож, урсгал зардлыг төсвөөс санхүүжүүлсэн;
- Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 262 дугаар тогтоолоор үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 10 боомтод үйл ажиллагаа явуулах 35365.2 га талбайг ашиглах эрхийг олгосон боловч 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор ашиглах эрхийг цуцалсан;
- Тус байгууллагатай холбоотой үйл ажиллагааны эх үүсвэр 2026 оны санхүүжилт батлагдаагүй, ажилтнууд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар түрээсийн байрны төлбөр төлөх боломжгүйгээс үйл ажиллагаа явуулах боломжгүй, цалин олгогдоогүй;
- Боомтуудад үйл ажиллагааг явуулж байгаа Хилийн боомтын захиргааны зарим чиг үүрэг давхардах, татан буугдсан тохиолдолд төсвөөс тэтгэмж, холбогдох зардлуудыг санхүүжүүлэх үр ашиггүй зардал гаргах эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт тусгагдаагүй байгууллагын үйл ажиллагааг дотоод зохицуулалтаар санхүүжүүлж байгаа асуудлыг зогсоож, шинээр нэмэгдсэн байгууллагын төсөв, орон тоо, урсгал зардлыг хуульд заасан журмын дагуу төсвийн тодотголд тусгуулан төсөв батлагдсаны дараа санхүүжүүлэх бодлого баримтлах.

Илрүүлэлт 2: Засгийн газрын нөөц хөрөнгөөс Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад тогтоомж, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, түүнийг дагаж гарсан Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журамд нийцэхгүй нийт 14,615.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д "Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.6.3-т "төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх;", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Засгийн газрын тусгай сангийн хууль тогтоомж нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.", Засгийн газрын нөөц сангийн зарцуулалтад хяналт тавих журмыг Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд журмын 1 дүгээр дүгээр зүйлийн 1.2-т "Нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл

ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.", Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой, бусад хууль тогтоомжид нийцээгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх, өөрийн эрхлэх асуудлын төсөвт хяналт хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг зохистой удирдах.

Илрүүлэлт 3: Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгдэж байгаа төсөл хөтөлбөрийн санхүү тайлагнал, санхүүжилтийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, гэрээний хугацаа, гүйцэтгэлийг захиалагч төсвийн ерөнхийлөн захирагчидтай жил бүрийн эцэст салбарын хэмжээнд хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлийг үнэлж, дүгнэж, хариуцлагыг тооцох асуудлыг шийдвэрлэдэг байх, эсхүл хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагчид төслийг бүрэн шилжүүлж, төсвийн зарцуулалтад санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллах эсэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна. Тухайлбал:

1. Хэрэгжиж байгаа төслүүдийн хувьд төсөл, арга хэмжээний эдийн засгийн тооцоо буруу хийгдсэнээс барилгын ажил, зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг нэмэгдэх, төсөл хэрэгжүүлэгч нэгж, захиалагч төсвийн ерөнхийлөн захирагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс гэрээний хугацаа удаа дараа сунгагдах, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ашиглаж байгаа тоног, төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусах, төсөвт өртөг нэмэгдэх, валютын ханшийн нөлөөнд орох, төсөв хэрэгжих боломжгүй нөхцөл байдалд хүрэх эрсдэлтэй;

2. Хэрэгжиж дууссан төслүүдийн хувьд төслүүдээс бий болж буй 144,005.0 сая төгрөгийн хөрөнгийг цаг хугацаанд нь ашиглагч байгууллага руу шилжүүлэхгүй байгаагаас хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдах, хариуцах эзэнгүй болох, төслийн санхүүгийн тайлангийн хаалт хийгдээгүй байна. Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургууль барих төсөл /БНХАУ/ 41,317.9 сая төгрөг;
- Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл 26,202.4 сая төгрөг;
- Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөл төсөл 25,932.0 сая төгрөг;
- Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл 24,726.7 сая төгрөг;
- Зам засвар арчлалтын 42ш машин төсөл 11,202.2 сая төгрөг;
- Гачууртын уулзвараас Налайх-Ч төсөл 9,299.0 сая төгрөг;
- Туул гол дээгүүрх Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл 4,199.4 сая төгрөг;
- Түлэнхийн төв барих төсөл 845.2 сая төгрөг;
- Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах" төсөл 150.6 сая төгрөг;
- Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл /БНСУ зээл/ 82.1 сая төгрөг;
- Цөмийн болон бусад аналитик аргаар хүнсний бүтээгдэхүүний эмийн болон химийн үлдэгдлийг шинэчлэх лаб-н чадавх сайжруулах төсөл 47.5 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.2.6а-д "тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх;", 6.3.3-т "төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын өрийн баталгаа, гадаад зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах;", 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой

удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Өрийн удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна.", 6.4.6-д "төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх;" 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "Засгийн газрын гадаад, дотоод өрийн үйлчилгээний хуваарийг гаргаж, улсын төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг тооцох, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах;" 30 дугаар зүйлийн 30.6-д "Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг Засгийн газрын тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан тодорхойлох бөгөөд төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална.", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх;", 5 дугаар зүйлийн 5.1.7-д "төсөл, арга хэмжээний хүрээнд бий болох үр дүн болон бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн тогтвортой, үр ашигтай ашиглах (удирдлага, хүний нөөц, санхүүгийн чадавх) төлөвлөгөө, түүнд шаардагдах төсвийн тооцоог (урсгал зардлын хамт) боловсруулан баталгаажуулсан байх.", 6 дугаар зүйлийн 6.12-т "Энэ журмын 6.11-д заасан нэмэлт, өөрчлөлтийн улмаас төсөвт нэмэлт дарамт, ачаалал учруулахгүй болох нь холбогдох тооцоо, судалгаагаар тогтоогдсон байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас зээлийн үндсэн төлбөрийг төлөх хуваарь, түүний эргэн төлөлтийн тооцооллыг баталгаажуулсан байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэх, төслийн хэрэгжилт, гүйцэтгэл, хугацаа, тайлагналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт хэрэгжүүлэх замаар үүрэг хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх.

## Түүврийн байгууллага:

### 4.4.2.2 Зөвлөмж

**Илрүүлэлт 1:** Нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байх зохицуулалтай боловч Засгийн газрын 2025 оны 18, 19, 27, 50, 152, 174, 175, 183, 251, 261 дүгээр тогтоолуудаар Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс ой тэмдэглэн өнгөрүүлэхэд 5,681.5 сая төгрөг, бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулахад 1,473.5 сая төгрөг, бүсийн хамтын ажиллагааг дэмжих спортын арга хэмжээнд 751.7 сая төгрөг, хөшөө дурсгал барьж байгуулахад 1,065.0 сая төгрөг нийт 8,971.7 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 24 дүгээр зүйлийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Засгийн газрын тусгай сангийн хууль тогтоомж нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.", Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор

улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх;", 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 13 дугаар зүйлийн 13.3-т "Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:", 13.3.1-т "хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах;", 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах.", Засгийн газрын нөөц сангийн зарцуулалтад хяналт тавих журмыг Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1 дүгээр дүгээр зүйлийн 1.2-т "Нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.", 2.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, албан ёсоор дэмжсэн санал өгсөн шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс бусад хууль тогтоомжид нийцээгүй, үр ашиггүй зардлыг санхүүжүүлэхгүй байх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулан ажилласан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 75.0 хувьтай байна.

Хүснэгт 16. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>75.0</b>

Өмнөх аудитаар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын алдаа, зөрчил нэмэгдсэн зөрчилд давтагдан гарсан боловч Монгол Улсын ерөнхий сайдын 2026 оны 76 дүгээр захирамжаар төсвийн ерөнхийлөн захирагч өөрчлөгдөн томилогдсон тул дахин албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах асуудлыг үзэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн төслийн саналыг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлж, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, түүнд шаардлагатай төсвийг үнэн зөв бодитой тооцоолж, тайлагнаж байгаа эсэх;
- Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн гарсан Засгийн газрын тогтоолын дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг зардлын ангилал бүрээр батлагдсан хязгаарт багтаан төлөвлөж байгаа эсэх;
- Төсвийн ерөнхийлөн захирагч өөрт олгосон эрхий хүрээнд батлагдсан төсөвт зохицуулалт хийхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал заавар”-ын зөрчиж бүлгийн дүнгээр хянагдах зардлуудыг бүлэг хооронд гүйлгэн зохицуулалт хийж зарцуулж байгаа эсэх;
- Татварын албаны улсын төсөвт төвлөрүүлэх 35,000.0 сая төгрөгийн татварын хүү торгуулийн орлого 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл гараагүй байгаа асуудалд анхаарч улсын төсвийн төсвийн орлогыг үнэн зөв, бодитой төлөвлөсөн эсэх;
- Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн ашиглалт, шууд төлбөрийн санхүүжилтийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэхэд нарийвчлан горим сорил хэрэгжүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дараагийн аудитаар Бичил санхүүгийн хөгжил сангийн 2025 оны санхүү байдлын тайлангийн үлдэгдэлд бүртгэлтэй байгууллагаас авах 370.3 сая төгрөг, хувь хүнээс авах 1,102.6 төгрөг, нийт 1,472.9 сая төгрөгийн авлага, 20.1 сая төгрөгийн ер төлбөрийн асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр санхүүгийн тайланд тусгаж, үнэн зөв толилуулсан эсэхийг үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 380,433.8 сая төгрөгийн 176 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан.

### Түүврийн байгууллагын алдаа

Аудитаар нийт 124,308.6 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Түлэнхийн төв барих төсөл хөрөнгөөр 2019-2024 он бэлтгэсэн 845.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/344 дугаар тушаалаар Гэмтэл согог судлалын үндэсний төвд шилжүүлсэн боловч бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй давхар бүртгэсэн;
- Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх-2 төслийн 2020-2024 онд бэлтгэсэн 11,820.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/345 дугаар тушаалаар Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд шилжүүлсэн байхад бусад эргэлтийн хөрөнгө данснаас хасаагүй хөрөнгө давхар бүртгэлтэй;
- Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн хөрөнгөөр бий болсон 111,642.9 сая төгрөгийн ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх, өртгийг найдвартай хэмжих боломжтой хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэж тайлагнаагүй, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 41-д “...тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн үеийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг...” гэж заасны санхүүгийн тайлангийн толилуулгын батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 183 төсвийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж, төвлөрүүлэн захирагч, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан, данс нэгтгэгдсэнээс “Өөрчлөлтгүй”-76, “Хязгаарлалттай”-22 санал дүгнэлт өгч, 67 байгууллага, 18 дансанд тус тус түүвэрт хамрагдсан.

Аудитаар нийт 418,216.6 сая төгрөгийн 234 зөрчил<sup>2</sup> илэрснээс 73.3 сая төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 46,522.1 сая төгрөгийн зөрчилд 88 албан шаардлага хүргүүлж, 370,760.0 сая төгрөгийн зөрчилд 113 зөвлөмж, 850.4 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 7 албан шаардлага хүргүүлж, 10.7 сая төгрөгийн 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар илэрсэн нийт 418,216.6 сая төгрөгийн залруулагдаагүй нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 361,928.8 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

### 5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 380,433.8 сая төгрөгийн алдаа, санхүүгийн тайлантай холбоотой 418,216.6 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 101,848.2 сая төгрөгийн зөрчил, нийт 900,498.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Санхүүгийн тайлантай холбоотой илэрсэн зөрчил нь өмнөх оноос 362,611.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайлантай холбоотой 404,452.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 355,917.1 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайлан аудитаар нийт 13,764.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 6,694.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дугаар зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг сайжруулах **албан шаардлага** хүргүүлэв.

### 5.2 Түүврийн байгууллагын аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

#### 5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Төслийн эскроу дансны үлдэгдэлд санхүүгийн тайлангийн хаалтын тайлан гарч баталгаажсан 3 төсөл хөтөлбөрийн нэгжийн 10.1 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хаагдсан төслүүдийн эскроу дансанд бүртгэлтэй зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 10.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

#### 5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтуудаар 3 үндэсний хороог шинээр байгуулж, харьяа төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудалд төсвийг батлалгүйгээр Засгийн газрын 61, 62, 70 дугаар тогтоолуудаар Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс төсөвт байгууллагын нэгэн адил үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж нийт 4,369.1 сая төгрөгийн зардал гаргасан

бөгөөд Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор тус хороонууд татан буугдсан байна. Үүнд:

- Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны орон тоог 15 байхаар баталж дунджаар 1 хүний цалинг 3.5 сая төгрөгөөр тооцож цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 924.8 сая төгрөг, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны орон тоог 15 байхаар баталж дунджаар 3.2 сая төгрөгөөр тооцож цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 902.3 сая төгрөгийг тус тус баталсан;
- Дээрх 2 хорооны үйл ажиллагааны зардал, тавилга эд хогшил, байрны түрээсийн зардал гаргаснаас гадна татан буугдсанаас хойш 1,725.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- Мөн аймгуудад шинэ хоршооны үйл ажиллагааг таниулах зорилгоор төсөвт өртгийг хувааж 5 аж ахуйн нэгжүүдтэй 100.0 сая төгрөгийн шууд худалдан авалтаар гэрээ байгуулсан;
- Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны үйл ажиллагааны зардалд нийт 1,055.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба гүйцэтгэлээр төсөвт өртөг хувааж шууд худалдан авалтаар 57 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан байна. Үүнд: Хэвлэл мэдээллийн 39 компанитай 765.3 сая төгрөгийг мэдээлэл сурталчлах түгээх /1, 2 дугаар сар/, 5 компанитай түрээсийн байр тохижуулахад 94.9 сая төгрөг, 6 компанитай 117.6 сая төгрөгийн судалгаа, 19.3 сая төгрөгийн бэлэг дурсгал, брошур танилцуулга хэвлүүлэхэд 3 компанитай 58.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Мөн Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 128 дугаар тогтоолын 45 дугаар хавсралтаар аж үйлдвэржилтийн төслүүдийг хэрэгжүүлэх, бэлтгэл хангах зорилгоор шинээр Аж үйлдвэржилтийн үндэсний хороог Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны чиг үүргийг давхардуулан 13 орон тоотойгоор байгуулж, үйл ажиллагааны зардалд 1,274.8 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд: Гадаад, дотоод томилолтын зардалд 155.6 сая төгрөг, хурал зохион байгуулахад 32.4 сая төгрөг, бусад үйл ажиллагааны зардалд 523.0 сая төгрөг, Хэвлэл мэдээллийн зардалд төсөвт өртгийг хувааж 11 компанитай 203.7 сая төгрөг, тавилга эд хогшил худалдан авахад 230.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, татан буугдсаны дараа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд шилжүүлсэн, хороо татан буугдахад ажилтнуудын ээлжийн амралтад 25.6 сая төгрөг, ажлаас чөлөөлөгдсөний 1 сарын нөхөн олговорт 44.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,"; 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3-т "захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Засгийн газрын 2021 оны 51 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд журмын 1 дүгээр дүгээр зүйлийн 1.2-т "Нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.", 2.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, албан ёсоор дэмжсэн санал өгсөн шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн Засгийн газрын шийдвэрийн төслийг журмын шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй,

Засгийн газрын нөөц хөрөнгөөс төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Боомтын хөгжлийн корпорац ТӨХХК-ийн арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгөд 13.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан боловч татвар нийгмийн даатгалын шимтгэлд 10.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан нь төсвийг зохистой удирдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Төсөл хөтөлбөрийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт 1: Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төслүүдээс бий болсон 53,269.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна. Үүнд:

- Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр хэрэгжиж дууссан Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд бий болсон Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/30 дугаар тушаалаар ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гарсан 2,366.4 сая төгрөг;
- Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр барих төслийн ажлыг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн эхлүүлсэн, Баянзүрхийн 321 у/м, 4 эгнээ зорчих хэсэг, явган хүний зам, үерийн хамгаалалтын далан бүхий шинэ гүүр барих болон Сонсголонгийн 289.4 у/м, 2 эгнээ зорчих хэсэг, явган хүний зам бүхий шинэ гүүр барьж, хуучин Сонсголонгийн гүүрийг засварлан 2021 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөр уг төсөл хэрэгжиж дууссан 4,199.4 сая төгрөг;
- МАЗ-5905А2-390 болон МАЗ-5337А2-348-600 маркийн тус бүр 21 ширхэг нийт 42 ширхэг машин механизм нийлүүлэгдэх бөгөөд тоног төхөөрөмжийг авто замын засвар, арчлалтын төрийн өмчит 20 компанид хуваарилах зорилготой 2021 оны 12 дугаар сарын 31-нд дууссан МАЗ-ын авто замын засвар, арчлалтын 42 ширхэг машин нийлүүлэх төслийн 11,202.2 сая төгрөг;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжсэн Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлийн төслийн ажлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ЗБ-23/03 дугаартай "Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлын хэсгийн акт, дүгнэлт"-ээр хүлээн авч, төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн 9,298.7 сая төгрөг;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж дууссан Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төслийн хүрээнд бий болсон Нийслэлийн Замын хөгжлийн газрын 02/947 дугаартай тушаалаар ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гарсан 26,202.3 сая төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,

санхүүгийн тайлан гаргах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.9-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх”; 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана”, 9 дүгээр зүйлийн 9.2.32-т “Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг баримтлан эцсийн өмчлөгчид шилжүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зээл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг захиалагчид шилжүүлэх талаар гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг холбогдох төсөл хөтөлбөрийн нэгжүүдэд хүргүүлэв.

### **Төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой**

**Илрүүлэлт 2:** Бүгд Найрамдах Франц Улс, Монгол Улсын Засгийн газартай Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөлд зориулан 60.7 сая еврогийн жилийн 0.0076 хувийн хүүтэй 40 жилийн хугацаатай, эхний 12 жилийн хугацаанд зээлээс чөлөөлөгдөх нөхцөлтэйгөөр нэн хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийг 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, гэрээний эрхийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс нээж, 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр буюу 3 жилийн хугацаанд ашиглаж дуусах хэлэлцээр хийсэн байна. Хэлэлцээрт төслийн хүрээнд 2 чиглэлд дүүжин тээврийг байгуулахаар 60.7 сая евро буюу 251,597.9 сая төгрөгийг шийдвэрлэсэн /Сангийн яамны тайлангаар тооцсон ханш 4,144.94 төгрөг/. Үүнд: Эхний шугамыг Баянхошуу-Ханын материал-3, 4 дүгээр хорооллын эцэс чиглэлээр барьж ашиглалтад оруулах, Хоёр дахь шугамыг 7 буудал-Дарь эх-Сансрын тойруу чиглэлд барихад шаардлагатай техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад 35.4 сая евро, хоёр дахь шугамыг барьж ашиглалтад оруулах дээд хэмжээ 25.3 сая евро байхаар тус тус баталсан.

Гүйцэтгэлээр Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 272 дугаар тогтоолын хавсралтаар чиглэлийг шинэчлэн баталсан ажлуудын төсөвт өртөг нэмэгдсэн, сүүлийн шугамыг суурилуулахад дахин төсөвт өртөг нэмэгдэх нэмэлт өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрээс санхүүжигдэх эрсдэлтэй байна. Үүнд:

- Баянхошуу-Ханын материал 3,4 дүгээр хорооллын эцэс хүртэл техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд 1.7 сая евро зарцуулсан боловч ажлыг зогсоож 7,071.4 сая төгрөгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан;
- “Яармаг, Арцат - Өнөр хороолол” чиглэлийн 4.2 км дүүжин замын ажилд 25.3 сая еврогийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр 2023 он гэрээний үнийг тохирсон боловч 2025 онд 41.6 сая евро болж 16.3 сая еврогоор буюу 67,562.5 сая төгрөгөөр төсөвт өртөг нэмэгдсэн;
- “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн - Үндэсний соёл амралтын хүрээлэн” чиглэлийн 2.6 км урттай дүүжин зам, тээвэр байгуулах ажлын төсөвт өртгийг 16.9 сая еврогоор тооцсон боловч хэлэлцээр хийсэн байгууллагын тооцоогоор 33.0 сая еврогоор 136,783.0 сая төгрөгийн төсөвт өртөг нэмэгдэхээр тооцож, эх үүсвэрийг илүү өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.2.6а-д "тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх;", 6.3.3-т "төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын өрийн баталгаа, гадаад зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах;", 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Өрийн удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна.", 6.4.6-д "төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх;" 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "Засгийн газрын гадаад, дотоод өрийн үйлчилгээний хуваарийг гаргаж, улсын төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг тооцох, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах;" 30 дугаар зүйлийн 30.6-д "Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг Засгийн газрын тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан тодорхойлох бөгөөд төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална.", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх;", 5 дугаар зүйлийн 5.1.7-д "төсөл, арга хэмжээний хүрээнд бий болох үр дүн болон бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн тогтвортой, үр ашигтай ашиглах (удирдлага, хүний нөөц, санхүүгийн чадавх) төлөвлөгөө, түүнд шаардагдах төсвийн тооцоог (урсгал зардлын хамт) боловсруулан баталгаажуулсан байх.", 6 дугаар зүйлийн 6.12-т "Энэ журмын 6.11-д заасан нэмэлт, өөрчлөлтийн улмаас төсөвт нэмэлт дарамт, ачаалал учруулахгүй болох нь холбогдох тооцоо, судалгаагаар тогтоогдсон байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас зээлийн үндсэн төлбөрийг төлөх хуваарь, түүний эргэн төлөлтийн тооцооллыг баталгаажуулсан байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Зээлээр хэрэгжиж байгаа төслийн ашиглалт, санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, хугацаанд нь төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлэх, төслийн гүйцэтгэлийн явцад гарч болзошгүй аливаа санхүүгийн эрсдэлээс үүдэн төсөвт үүсэх ачааллыг бууруулах боломжит хувилбартай байх.

#### **Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой**

**Илрүүлэлт 4:** Боомтын хөгжлийн корпорац ТӨХХК нь тайлант онд үндсэн чиг үүргийн ажлыг хэрэгжүүлээгүй боловч төсвөөс 100.0 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардал, цалинд 86.8 сая төгрөгийн зардал гаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал, цалин нийгмийн даатгалын шимтгэлийн шардалд 63.5 сая төгрөг, түрээсийн гэрээг сарын 5.0 сая төгрөгөөр 1 жилийн хугацаатай байгуулж, гүйцэтгэлээр 5.1 сая төгрөг, веб сайт хөгжүүлэх зардалд 1.7 сая төгрөг гэх мэт урсгал зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн өмчит компани өөрийн орлогоор бүрэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх эрх зүй, санхүүгийн орчин бүрдээгүй байхад төсвөөс санхүүжилт авч зарцуулалт гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР</b>													
1	Санхүүгийн мэдээллийн технологийн төв	1	36.5	1	36.5			1	36.5				
2	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	7	1,337.8	7	1,337.8			7	1,337.8				
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>1,374.3</b>	<b>8</b>	<b>1,374.3</b>	-	-	<b>8</b>	<b>1,374.3</b>	-	-	-	-
<b>ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР</b>													
1	Инженер, технологийн дээд боловсрол төсөл	1	0.5	-	-	1	0.5	1	0.5				
2	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	3	805.1	3	805.1		-	3	805.1				
3	Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл	2	552.0	1	4.9	1	547.1	2	552.0				
4	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	1	91,114.9	1	91,114.9		-	1	91,114.9				
5	Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төсөл	5	21,740.7	2	5,810.0	3	15,930.7	5	21,740.7				
6	"Ногоон нуур 1008 айлыг орон сууц" ТХН	2	30.9	1	19.4	1	11.4	2	30.9				
7	"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл	3	383.7	3	383.7		-	3	383.7				
8	Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр -I шат	2	98.8	2	98.8		-	2	98.8				
9	Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл	2	458.4	-	-	2	458.4	2	458.4				
10	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	1	136.7	1	136.7		-	1	136.7				
11	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл	3	1,055.3	3	1,055.3		-	3	1,055.3				
12	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 3 дугаар үе шат	2	5,011.3	1	3.2	1	5,008.1	2	5,011.3				
13	Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл	1	2,306.8	-	-	1	2,306.8	1	2,306.8				

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	2	1,661.3	2	1,661.3		-	2	1,661.3				
15	Монгол Улсад COVID-19 Халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	7	100.2	4	91.1	3	9.1	7	100.2				
16	Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл	5	5,148.0	4	4,297.0	1	851.0	5	5,148.0				
17	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	2	1,096.0	2	1,096.0		-	2	1,096.0				
18	Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл	2	19.7	1	19.7	1	-	2	19.7				
19	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл - /3787/	1	3,383.5	-	-	1	3,383.5	1	3,383.5				
20	Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл	3	124.9	3	124.9		-	3	124.9				
21	УБ-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл /ЕСБХБ/	2	51,834.0	2	51,834.0		-	2	51,834.0				
22	Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл	5	19.8	5	19.8		-	5	19.8				
23	Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл	1	1,613.3	1	1,613.3		-	1	1,613.3				
24	Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл	1	13.0	-	-	1	13.0	1	13.0				
25	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (MON48076-002/3605-MON/9191-MON)	2	45.7	2	45.7		-	2	45.7				
26	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл	3	51,610.7	2	51,610.7	1	-	3	51,610.7				
27	Чойр Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35кВ-н дэд станц барих төсөл	6	856.2	3	40.5	3	815.7	6	856.2				
28	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн төслийг хөгжүүлэх нь*	5	1,669.6	1	3.6	4	1,665.9	5	1,669.6				
29	Эрчим хүчний сүлжээнд том чадлын хуримтлуурын төсөл	3	32.9	3	32.9		-	3	32.9				
30	Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл	1	111,642.9		-	1	111,642.9	1	111,642.9				
31	Түлэнхийн төв барих төсөл	1	845.2		-	1	845.2	1	845.2				
